ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-27

1.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох 3-27

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы Өргөдлийн байнгын хорооны 11 дүгээр сарын 12-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 05 минутад Төрийн ордны "Жанжин Д.Сүхбаатар" танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганмаа, Р.Эрдэнэбүрэн;
Чөлөөтэй: Х.Баттулга, С.Ганбаатар, Ц.Идэрбат, Ц.Мөнхтуяа, Б.Пунсалмаа, М.Сарнай, Ч.Ундрам.

Нэг.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын шинжээч И.Дабааноров, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Г.Жаргалсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхтөр, Боловсролын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Ренчиндорж, мөн яамны Цахим боловсролын бодлого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга М.Мөнхсанчир, Салбарын хяналтын хэлтсийн дарга Г.Наранбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Э.Батболд, мөн яамны Хот дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мөнхжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга О.Цолмон, мөн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга П.Оростогоо, ахлах мэргэжилтэн О.Одонтунгалаг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, мөн газрын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Д.Шижир-Эрдэнэ, ажилтан Д.Норжмаа, Э.Гантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дарга Н.Мишигдорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Б.Батболд, мөн газрын Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Золбоо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхжаргал, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Э.Эрдэнэсайхан, "Нийслэлийн орон сууцны корпораци" хувьцаат компанийн захирал Д.Жавхлан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, М.Мандхай нар байлцав.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр,

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дарга Н.Мишигдорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхтөр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга О.Цолмон нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Баасанжаргал, С.Замира, О.Номинчимэг, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Э.Батболд, мөн яамны Хот дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мөнхжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга О.Цолмон, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дарга Н.Мишигдорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Б.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонслоо.

Үг асуудлыг 13 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 37 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 05 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээхэд бэлэн болсон байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/ болон Засгийн газар /ЗГ/-ын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг өнөөдөр сонсохоор байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байгаа эсэхийг тодруулъя. Байхгүй байна.

Монгол УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд хандан иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ЗГ, түүний харьяа яам, агентлагийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаарх өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын өнөөдрийн мэдээллийг сонсож, хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр сайд оролцож байна, ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/-ын дарга Эрдэнэбулган, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын ахлах шинжээч Даваанаров, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/ Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны ТНБД Эрдэнэбаяр, Боловсролын яамны ТЗУГ-ын дарга Ренчиндорж, Боловсролын яамны Цахим боловсролын бодлого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Мөнхсанчир, Боловсролын яамны салбарын хяналтын хэлтсийн дарга Наранбаатар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхтөр, Нийгмийн даатгалын ерөнхий газар /НДЕГ/-ын дарга Батжаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Батболд, Хууль зүй, дотоод хэргийн яам /ХЗДХЯ/-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Цолмон, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын газрын дарга Оростогоо, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Одонтунгалаг, Цагдаагийн ерөнхий газар /ЦЕГ/-ын Мөрдөн шалгах албаны дарга, цагдаагийн хурандаа Мишигдорж, Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ерөнхий газар /ШШГЕГ/-ын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Батболд, ШШГЕГ-ын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Золбоо, Улсын бүртгэлийн ерөнхий газар /УБЕГ/-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхжаргал, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт, судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга Баярмаа, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Бодлого, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Шижир-Эрдэнэ, НЗД-ын орлогч Жаргалсайхан, Нийслэлээс байна уу? Жаргалсайхан даргыг дуудаарай. Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга Эрдэнэсайхан, Нийслэлийн орон сууцны корпорац ХК-ийн захирал Жавхлан, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт, судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Бодлого, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан Норжмаа, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт, судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан Гантуяа нар оролцож байна.

Бид сар тутамдаа эсхүл 2 сар тутамдаа Өргөдлийн байнгын хорооноос ЗГ болон түүний харьяа агентлагуудад шилжүүлсэн өргөдлийнхөө хэрэгжилт, биелэлт ямар байгаа талаар байнгын, тогтмол сонсохоор төлөвлөж ажилладаг. Гэхдээ өмнөх өргөдлүүдийг дандаа ерөнхий байдлаар, тоо, дүн шинжилгээ байдлаар танилцуулж байсныг энэ удаа болиод яг Өргөдлийн байнгын хороон дээр ирсэн хувь кэйсүүд /case/ ямар шийдвэрлэлтийн явцтай байна, тэр хувь өргөдөл гаргасан, гомдол гаргасан иргэдийн асуудал хэрхэн шийдэгдэж байна гэдгийг бодитоор харж хэлэлцэх ёстой гээд арга барилаа өөрчилсөн байгаа. Тэгэхээр өнөөдөр Өргөдлийн байнгын хороон дээр манай гишүүдэд бүгдээрэнд нь гүүгл драйв /Google Drive/ дээр бүх өргөдлүүд мэдээлэлтэйгээ очсон байдаг листээрээ. Тэгээд ЗГ-т аль алийг нь шилжүүлсэн, одоо ямар явцтай байгаа гэдэг мэдээллийг Байнгын хорооны ажлын албанаас бэлдэж хүргүүлсэн байгаа. Тэгээд энэ дээр яагаад энэ асуудлууд хэрэгжилт нь ямар байна, хэрэгжсэн бол сайн байна, хэрэгжээгүй бол юун дээрээ гацаад байна гэдгийг бид өнөөдөр хэлэлцэх гэж байгаа.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр хийнэ. Танилцуулга, эхлээд Энхбаяр сайд ерөнхий танилцуулга хийнэ гэж ойлгож байгаа шүү дээ, зөв үү? Тэгээд 73 кэйстэй холбоотой бид нарийвчилсан асуудлуудыг ярих болно гээд хэлье. Баттөмөрийн Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын дарга, гишүүд, Өргөдлийн болон ХЗБХ-нд иргэн, хуулийн этгээдээс ирүүлж шийдвэрлүүлэхээр ЗГХЭГ, яам, ЗГ-ын агентлаг зэрэг 18 байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд хамаарах нийтдээ 73 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар танилцуулъя. Эдгээрийн 40 нь буюу 54.8 хувь нь орон сууцтай холбоотой бөгөөд бусад нь тэтгэвэр, тэтгэмж, гал түймэр, үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирол зэрэг иргэдийн амьдрал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шууд хөндсөн асуудлууд байна. ЗГ-ын зүгээс өргөдөл, гомдлыг нэг бүрчлэн шийдвэрлэхийн зэрэгцээ тэдгээрийн шалтгаан нөхцөлийг арилгах, иргэдийн эрхийг хамгаалах, ижил төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд голлон анхаардаг. Энэ хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэрлэлтийн явц болон цаашдын зорилтыг дараах 4 чиглэлд танилцуулъя.

Нэгд, Орон сууцны захиалгатай холбоотой иргэдийн эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд. Нийт өргөдөл, гомдлын талаас илүү хувийг орон сууц захиалж хохирсон, орон сууцтай болоход дэмжлэг хүссэн, орон сууцны чанар ашиглалтад

шаардлага хангахгүй байгаа зэрэг асуудал эзэлж байгаа нь энэ чиглэлд иргэдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн байгууллагуудын хяналт, зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. ЗГ энэ асуудлыг зөвхөн үүссэн зөрчил, маргааныг шийдвэрлэх хүрээнд бус иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дахин хохирох эрсдэлийг бууруулах бодлогын түвшинд авч үзэж байна.

Энэ хүрээнд УИХ-ын 2026 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Ерөнхий сайдын 2026 оны 154 дүгээр захирамжаар ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, орон сууцны захиалгын гэрээний улмаас хохирсон иргэдийн эрх, хууль ёсны асуудлыг хамгаалах, үүссэн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ажлын хэсгийн хүрээнд холбогдох байгууллагуудын шийдвэрлэж байгаа 879 өргөдөл, гомдлын 724 буюу 83.2 хувийг шийдвэрлэж, 155 өргөдөл, гомдлыг үргэлжлүүлэн шалгаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд иргэдэд нийтдээ 3.2 тэрбум төгрөгийн хохирол, эд хөрөнгийг олгож, 44 иргэний үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг гаргуулсан байна. Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг УИХ-ын Өргөдлийн байнгын хороо болон ЗГ-ын хуралдаанд танилцуулсан.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд барьж дуусаагүй орон сууц захиалагчийн ирээдүйд өмчлөх эрхээ шилжүүлэн авахыг шаардах эрхийг улсын бүртгэлээр хамгаалах, нэг орон сууцыг давхардуулан захиалах, барьцаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, барилгын зөвшөөрөл болон орон сууцны захиалгын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн үндэслэлийг боловсруулж, 2026 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлээд байна. Мөн ЗГ-ын 2026 оны 406 дугаар тогтоолоор барилгын зөвшөөрөл, орон сууцны захиалгын мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллагад цахимаар хүргүүлэх, иргэд гэрээ байгуулахаас өмнө тухайн сууц, талбайд урьдчилсан тэмдэглэл, захиалгын гэрээ бүртгэгдсэн эсэхийг нягтлах боломжийн талаар олон нийтэд мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗГ-ын 2026 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаас барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл болон зураг төсөл, инженерийн дэд бүтцийн техникийн нөхцөлтэй холбоотой асуудлыг төсөл бүрээр нягтлан шалгаж хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад даалгасан. Эдгээр арга хэмжээ нь үүссэн зөрчлийг шийдвэрлэхээс гадна орон сууц захиалагчдын эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг бэхжүүлэх, мэдээллийн ил тод байдал, төрийн байгууллагын хяналтыг сайжруулахад чиглэж байгаа бөгөөд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд батлагдсанаар давхар захиалга, залилангийн эрсдэлийг бууруулж, иргэд дахин хохирохоос урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Хоёрт, Ахмад настны тэтгэвэртэй холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар. Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой өргөдөл, гомдол нь иргэдийн нийгмийн баталгаа, амьжиргаатай шууд холбогдох ба хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үүссэн асуудлыг бодитой шийдвэрлэх нь чухал. Иргэдээс тэтгэврийн зөрөөг арилгах, тэтгэвэр тогтоох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх, шинээр тэтгэвэр тогтоолгох, төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийг нөхөн олгох, уг тэтгэмжийг гэр бүлийн гишүүдэд нь өвлүүлэхтэй холбоотой өргөдөл, гомдлыг ирүүлдэг. УИХ-аас 2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр баталсан төсвийн тодотголоор Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсныг үндэслэн ЗГ-ын 2026 оны 416 дугаар тогтоолоор суурь тэтгэврийн хэмжээ, тооцооллын үзүүлэлт, дээд хэмжээг тогтоож, нийгмийн даатгалын

сангаас болон цэргийн тэтгэвэр авагч ахмад настнуудад 2026 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шимтгэл төлсөн хугацаа болон үндсэн тэтгэврийн хэмжээнээс хамааруулан сард 100 мянгаас 300 мянган төгрөгийн суурь тэтгэврийг хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу олгохоор шийдвэрлэлээ. Мөн тэтгэвэр бодоход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтооход шаардагдах 328.5 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн төсөлд тусгаад байна.

Гуравт, Гал түймэр, үйлдвэрлэлийн ослын улмаас иргэдэд учирсан хохирол, хохирсон иргэдэд үзүүлэх дэмжлэгийн чиглэлээр. Иргэдийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтэд ноцтой хүндрэл учруулсан зарим асуудлыг ЗГ-ын түвшинд хэлэлцэн тодорхой шийдвэрүүдийг гаргасан. Шинэ Улаангом худалдааны төвийн гал түймэрт хохирсон иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр ЗГ-ын 2026 оны 30 дугаар тогтоолоор 5.6 тэрбум төгрөг шийдвэрлэснээс 259 иргэнд нийтдээ 5 тэрбум төгрөгийг 48 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй олгосон.

Бэрхийн уурхайд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан болон нас барсан уурхайчдын нөхөн төлбөрийн асуудлаар нэр бүхий 112 иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй харилцан тохиролцох, ижил нөхцөл байдал бүхий бусад уурхайн асуудлыг нэгтгэн судлах, шаардагдах санхүүжилтийн саналыг боловсруулж, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Эрхэм байнгын хорооны гишүүд ээ, иргэдийн өргөдөл, гомдлыг зөвхөн шийдвэрлэж хариу өгөх бус тэдгээрээс үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг арилгаж, ижил төрлийн асуудал дахин гарахаас урьдчилан сэргийлэх нь чухал байна. Энэ хүрээнд өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн системээр дамжуулан бүртгэл, шийдвэрлэлтийн явц, үр дүнд тогтмол хяналтыг сайжруулж өргөдөл, гомдлын төрөл, шалтгаан, давтамжид тогтмол дүн шинжилгээ хийхээр ажиллаж байна. Уг дүн шинжилгээнд үндэслэн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн нийтлэг асуудлыг шийдвэрлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч шаардлагатай тохиолдолд хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход голлон анхаарна. ЗГ-ын зүгээс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг зөвхөн шийдвэрлэсэн өргөдлийн тоо, хугацаагаар бус иргэдийн эрх, хууль ёсны сонирхлыг бодитой хамгаалсан эсэх, асуудлыг үүсгэсэн шалтгаан нөхцөлийг арилгасан эсэх, ижил төрлийн зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлсэн үр дүнгээр үнэлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн хавсралтаар хүргүүлсэн. Анхаарал тавьсанд баярлалаа.

О.Номинчимэг: Энхбаяр сайдад баярлалаа. Өргөдлийн байнгын хороон дээр манай гишүүдэд бүгдээрэнд нь мэдээлэл очиж байгаа. Бид 14 хоногтоо энэ тоо, дүн шинжилгээний график, инфографикийг /infographic/ гаргаад гишүүддээ мэдээлэлжүүлдэг. Бидэнд ирж байгаа иргэдийн өргөдөл, гомдлуудын дийлэнх буюу хамгийн их хувь нь төрийн байгууллага, албан тушаалтнуудын хууль бус ажиллагаа, хүнд сурталтай холбоотой асуудал байгаад байгаа. Тэгээд энийг яалт ч үгүй бид мэдээж Өргөдлийн байнгын хороо дангаараа аваад шийдчихгүй. Бусад оролцогч талуудын мэдээллийг авна, шийдвэр гаргалт нь яаж явсан юм гэдэг асуудлыг судлах үүргийг ЗГ-т өгдөг байгаа.

Хоёр дахь нэг том асуудал яалт ч үгүй энэ Өргөдлийн байнгын хорооноос санаачилга гаргаад орон сууцны залилантай холбоотой асуудлыг хөндөж тавиад энийг хаа хаанаа ойлголцоод, ЗГ ч гэсэн шуурхай арга хэмжээ аваад тодорхой үр дүнгүүд эхнээсээ гарч байгаад их баяртай байгаа. Иргэд ч гэсэн энийг хараад засаг төр биднийхээ дуу хоолойг сонсдог юм байна гэдэг итгэл төрж байгаа гэдгээ Өргөдлийн байнгын хороонд

илэрхийлж байгаа. Бид нийтдээ одоогоор 150-аад өргөдөл ЗГ руу шилжүүлсэн. Эндээс хариу ирээгүй асуудлуудтай холбоотой өнөөдөр мэдээллүүдийг нь багцлаад гишүүдэд хүргэсэн байгаа. Тэгэхээр бид мэдээж нийтлэг эрх ашиг, урьдчилан сэргийлэх, учир шалтгаант холбоог нь олж тогтоогоод энэ үүсгэж байгаа нөхцөл байдлыг нь арилгах юун түрүүн чухал.

Гэхдээ бид Өргөдлийн байнгын хорооны нэг чиг үүрэг бол энэ нэг гэлтгүй иргэнийхээ өргөдөл, гомдлыг сонсож энэ дээр асуудал юу байна гэдгийг Гүйцэтгэх засаглалтайгаа дунд нь арбитраж /arbitration/-н маягаар хурдлуулах, зөв шийдэл гаргах дээр нь ажилладаг ийм Байнгын хороо байгаа. Тэгэхээр бид яалт ч үгүй өнөөдөр хувь кэйсүүд дээр шийдвэрлэлт ямар байгаа талаар хэлэлцэхээр байгаа. Тэгэхээр эхний, ер нь 72 иргэнтэй холбоотой, 72 өргөдөлтэй холбоотой асуудлуудыг гишүүддээ багцалж өгөөд, түүн дээр ЗГ ч гэсэн өөрсдийнхөө тайлбарыг ирүүлсэн байгаа. Тэгэхээр нэг бүрчлэн сонсоод, гишүүдийн зүгээс ч гэсэн энэ дээр манай гишүүд ажлын хэсэгт орж ажиллаж байгаа, олон иргэд өөрсдөө холбогддог. Асуултаа асууж, тодруулах зүйлээ хэлэлцүүлгийг эхлүүлье.

Эхлээд Өргөдлийн байнгын хороон дээр хамгийн их ирүүлээд байгаа орон сууцны захиалга өгч хохирсон Цэен, Төгсжаргал, Сумъяасүрэн, Гантуяа, Азжаргал, Батаа, Болормаа, Амарбаяр, Бямбадорж, Алтанчимэг, Алтанцэцэг, Батбаатар, Содбаяр, Болдбаатар, Сэргэлэн, Хандсүрэн, Цогт, Бямбажав, Мөнгөнчимэг, Отгонбат, Өнөрбаяр, Батсүрэн, Эрдэнэсүрэн, Дулмаасүрэн, Нэмэхбаяр, Чимэгсүрэн, Ганболд, Бадамцэцэг нарын болон Марч констракшн, Поларис барилгын хохирогч 1361 иргэний төлөөлөл Итгэл ТББ, Зөв гарц оновчтой шийдэл гишүүнд үйлчлэх ТББ-ын төлөөлөл, Эрхэм үнэт зүйл ТББ, Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо гишүүнд үйлчлэх ТББ нийт 34 иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээллийг сонсъё.

Тэгэхээр энэ гол нь манай тайлбар хийх гэж байгаа ХЗДХЯ-наас сонсох юм байна. Том ажлын хэсэг гарсан. Энэ дээр их идэвхтэй үр дүн гаргаж ажиллаж байгаа гэдэг мэдээллийг бид ч гэсэн өмнө нь сонссон. Гэхдээ яг энэ одоо яах вэ, урьдчилан сэргийлэх журам, түр журам гарсан, хууль ЗГ-аас өргөн барьсан, удахгүй УИХ-аар хэлэлцэнэ. Цаашид гарах урьдчилан сэргийлэх ажлыг бид хангалттай хийж байгаа. Яг энэ хохирчоод байгаа иргэдийн асуудал, жишээ нь тэр Марч констракшны Поларис барилга чинь одоо яг яах вэ? Энэ гацчихаад байгаа баахан царцчихаад байгаа барилгуудаа яах шийдэлд хүрсэн бэ? Тэр нэг зөвшөөрлийн асуудал яригдаад байсан, зөвшөөрөлгүй барьсан барилга дээр ямар ч дахиж зөвшөөрөл олгогдож чадахгүй ингээд үйл ажиллагаа нь зогсоод байна гэдэг асуудлыг энэ иргэд дахин, дахин Өргөдлийн байнгын хороонд ирүүлээд байгаа асуудлыг яаж шийдвэрлэж байна гэдэг дээр тулгуурлаж та бүхэн мэдээллээ өгөхийг хүсье. ХЗДХЯ-наас мэдээлэл өгөх юм байна, хэдэн номер билээ? 3 номерын микрофон.

Н.Мишигдорж: Нийт Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Мөрдөн шалгах албаны дарга, хурандаа Мишигдорж. Сая нэр дурдсан иргэд түрүүний дээр дурдсан Марч констракшн компанитай холбоотой хохирогч нар байна. Энэ иргэдийн гомдлыг хүлээж аваад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /ЭХХШТХ/-ийн 15.4-д зааснаар хүсэлтийг хангаад, эрүүгийн хэрэг үүсгээд холбогдох этгээдийг яллагдагчаар татаад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Яг бидэнд Голден Пэйж Аудитын газрын дүгнэлт, мөн Барилгачдын төсөвчдийн нэгдсэн холбооны дүгнэлт 2 гарчихвал энэ хэрэг дээр шинжээчийн дүгнэлтийг болон хавтаст хэргийг хохирогч нарт танилцуулаад шийдвэрлэхэд бэлэн болчхоод байгаа. Шинжээчийн дүгнэлт тодорхой хугацаанд гарах ёстой. Мөн дээрээс нь шинжээчийн дүгнэлттэй холбоотой зардлуудыг бүрэн шийдвэрлээд яг одоо бидний өнөөдөр энэ хуралдаж байх хугацаанд шинжээч нартайгаа манай ажлын

хэсгийнхэн уулзаад дүгнэлтээ хэзээ гаргах вэ гэдэг талаараа хэлэлцээд сууж байна. Энэ 12 сарын 15-ны дотор энэ хэргийг эцэслэн шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байгааг танилцуулъя.

О.Номинчимэг: Үүнтэй холбоотойгоор гишүүдээс асуулт асуух, зөвхөн саяын, асуудал, асуудлаар нь явчихъя. Тэгэхгүй бол энэ чинь багц баахан юм яачхаад дундаас нь асууна гэхээр. Марч констракшны эрүүгийн хэрэг ингээд явж байгаа гэдэг асуудал байна шүү дээ, хэзээ шийдвэрлэх вэ дээр? Асуухгүй байвал яах вэ дараагийнх руугаа шууд явчхаж болно шүү дээ. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Багцлаад бид өргөдлүүдээ ярилцаж байна. 2 гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд энэ орон сууцны залилантай холбоотой асуудлууд газар авч ерөөсөө дуусахгүй байна. Хэдийгээр ажиллаад байгаа ч гэсэн тодорхой үр дүн гарч байгаа байх. Гэхдээ энэ хаанаа байна гэдэг учир шалтгаанаа хэдүүлээ их сайн нарийн тодорхойлж тэрийг нь таслан зогсоохгүй бол ингээд л үргэлжлээд залилан хийгдсээр л, гарсаар л байхаар түвшинд байгаа. Зүгээр миний ойлгож байгаагаар өргөдөл өгсөн хүмүүсийн түвшинд л гэж харж байгаа.

БНСУ болон бусад улсуудад амьдарч байгаа, ажил хийж байгаа иргэд маань Монгол Улс руу орон сууц худалдан авахаар мөнгө төгрөг шилжүүлдэг. Тухайлбал барилгын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд, тодорхой брокерын пүүсүүд тухайн улсад очиж тодорхой хэмжээнд сурталчилгаа хийж мөнгийг нь авдаг, сар болгон данс руугаа авдаг тохиолдлууд ч байгаа. Тэгээд энэнтэй холбоотой ер нь өргөдөл, гомдол ирсэн болов уу? Энэ дээр тодорхой хэмжээний хэрэг үүссэн, хэрэг төвөг байгаа болов уу гэж би нэгдүгээрт асуух гэж байгаа?

Хоёрдугаарт, ер нь энэ барилгын компани дампуурчихвал энэ иргэдийн мөнгийг яг хэн хамгаалах вэ? Ингээд залилан хийсэн, ингэсэн, тэгсэн гээд сая нэлээн олон хохирогчтой компанийн асуудал ярьж байна. Захирлыг нь юм уу, хэн нэгнийг нь яллагдагчаар татчихсан юм шиг байна. Тэгээд энэ компани дампуурлаа албан ёсоор зарлачихвал хуулийн дагуу энэ иргэдийн мөнгийг яг хэн хамгаалах вэ гэдгийг тодруулж асуумаар байна? Ийм 2 асуулт.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Хууль зүйн яамнаас хүн байгаа юм уу? Хэн, 3 номер юм уу, хэдэн номер вэ? 3 номер гишүүний асуултад хариулъя.

Н.Мишигдорж: Уучлаарай, энд сонсогдоогүй болохоор бид яг ямар асуулт тавьчихав гээд ярилцаад байна л даа, сая сонсогдсонгүй, уучлаарай.

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнд микрофон дахиж өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би уул нь чанга л яриад байх шиг байх юм, бүгдээрээ л сонсоод л байх шиг байна, хоорондоо ярихаа больчихвол сонсогдох байх. 2 асуудал байгаа юм. Нэгдүгээрх асуудал нь бол энэ гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдээр чинь барилгын компаниуд тойроод, брокерын пүүсүүд тойроод, банк бус санхүүгийн байгууллагууд чинь тойроод байшин худалдаж байна. Та сар болгон ажиллаж байгаа мөнгөнөөсөө тодорхой мөнгийг ийм данс руу шилжүүлээд бай, тэгээд энэ данс руу чинь шилжээд та Монголд бараг ажлаа дуусаад Монголдоо ирэхэд шинэ байртай болчихсон байна гэж хэлээд ингээд мөнгө цуглуулаад байна. Энэ дээр ирсэн ямарваа нэг гомдол, гадаадад амьдарч байгаа Монголчуудаас ирсэн гомдол мэдээллүүд байгаа юу нэг?

Нөгөөдөх нь жишээлбэл сая эзэн холбогдогч нэлээн олонтой барилгын компанитай холбоотой хэргийг та бүхэн ярьж байна шүү дээ. Яллагдагчаар татсан гэж байх шиг байна. Тэгээд энэ барилгын компани чинь өөрөө албан ёсоор, энэ миний минутыг бүтнээр нь өгөх үү, сая дахиад ярь.../минут дуусав/

О.Номинчимэг: Нэмэлт нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Би нэмэлтээ авна шүү. Би түрүүн асуух асуултаа минутдаа багтаагүй явж байгаа шүү. Хоёрдугаарт, барилгын компани чинь албан ёсоор хуулийн дагуу мөнгийг нь төлж чадахгүй гээд албан ёсоор хуулийн дагуу дампуурлаа зарлачихвал Дампуурлын хуулиараа шийдэгдээд явчихаар энэ иргэдийн мөнгийг хэн хамгаалах вэ, ямар хариуцлага хүлээх вэ гэдэг хоёрдугаар асуулт байна? 2 дугаар асуулт нь.

Гуравдугаар асуулт нь бол энэ дахин төлөвлөлттэй холбоотой асуудлууд байгаа. Дахин төлөвлөлт дээр барилгыг нь барьж өгнө гээд тэр Бат-Үүл баатрын үед баахан барилгын компаниуд газар төлөвлөлт хийгээд, нөгөө хүмүүс нь хэдэн жил гудамжинд гараад амьдарцгаасан. Тэгээд ийм нөхцөл байдалтай холбоотой асуудлууд одоо бий юү? Одоо зөвхөн орон сууцны залилан яриад байна шүү дээ. Тэгвэл орон сууцны залилангаас гадна барилгын дахин төлөвлөлт хийнэ гэж орж байгаа компаниуд тухайн заасан хугацаандаа барилгаа барьж чадаагүй иргэдийг залилсан тохиолдол юм уу.../минут дуусав/

О.Номинчимэг: Асуулт ойлгомжтой тийм ээ? Асуулт ойлгомжтой. 2 номерын микрофон, гишүүний асуултад хариулъя.

Э.Батболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны газрын дарга Батболд. Орон сууцны залилантай холбоотойгоор одоогийн байдлаар гадаадад ажил хөдөлмөр эрхлээд тэндээсээ дамжуулаад барилгын компанид залилуулсан гэсэн одоогийн байдлаар бүртгэгдсэн гомдол одоохондоо бидэн дээр ирээгүй байгаа.

Дээрээс нь дахиад энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой нийтдээ урьдчилсан байдлаар нийслэлээс ирүүлж байгаа мэдээлэл дээр 735 нэгж талбарын өрхүүд газраа чөлөөлөөд, тухайн төсөл дээр нь орон сууц нь ашиглалтад ороогүй байгаатай холбоотой зөрчилтэй холбоотой асуудлууд ирүүлсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн 7 хоногийн ЗГ-ын хуралдаанаар энэ орон сууцны залилантай холбоотой шийдвэрийг гаргасан байгаа. Тэр нь юу вэ гэхээр энэ барилгын ажлын зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль сая 7 сарын 3-нд батлагдсантай холбоотойгоор энэ зөвшөөрлийн асуудлуудаа шийдвэрлээд явахыг чиглэл болгосон. Нөгөөдөх нь болохоор түрүүчийн хэлсэн энэ дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдаад энэ орон сууцдаа одоо болтол орж чадаагүй байгаа иргэдийг энэ төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны хорооллуудад үе шаттайгаар ингэж оруулаад, тэгээд тухайн төсөл дээр нь төсөл хэрэгжүүлэгдээд байшин нь орохоор нь буцаагаад түүн рүү нь оруулах гэдэг энэ зохицуулалтуудыг хийхээр шийдвэрлэсэн. Энэ холбоотойгоор БНХАУ-ын 1008 айлын орон сууцны төсөлд эхний ээлжийн хохирогчдыг оруулах ажлыг ингээд энэ 11 сардаа багтаагаад зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байгаа.

Яг энэ орон сууцны залиланг хийгээд компани дампуурлаа зарлаад нэгэнт төлбөрөө өгчихсөн байгаа иргэдэд одоо байгаа эрх зүйн зохицуулалтын асуудлаар ХЗДХЯ-наас хариулт өгөх байх. Манай яамнаас өргөн барьчихсан байгаа энэ Орон сууцжуулалтын тухай хууль дээр бас энэ иргэдийн орон сууцны захиалга өгөөд хохирдог асуудлуудыг

шийдвэрлэх зорилгоор сая ХЗДХЯ-тай хамтраад түр бүртгэл хийх буюу давхар гэрээ авах асуудлыг зохицуулж өгсөн. Дараагийнх нь болохоор энэ иргэд төлбөрөө төлчхөөд, төлсөн төлбөрөө яаж найдвартай хадгалах вэ гэдэг асуудлыг энэ Орон сууцжуулалтын тухай хууль дээрээ энэ эскроу /escrow/ данс гэдэг зүйлийг ашиглаад тухайн төслийн мөнгийг нэг дансанд байршуулах байдлаар хуулийн зохицуулалтуудыг оруулсан. Тэгээд ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд удахгүй Их Хуралд хэлэлцэгдээд явбал энэ эрх зүйн зохицуулалт буюу иргэдийн мөнгийг дансанд нь хадгалдаг байх ийм зохицуулалтууд шинээр бий болох ийм боломжтой байгаа.

О.Номинчимэг: ХЗДХЯ-наас хэн байна, хэдэн номер дээр байна? Эсхүл сая Бат-Эрдэнэ гишүүний тэр дампуурчхаад, тэгээд яг энэ иргэд чинь тэгвэл яг хохирлоо яах вэ? Эрүүгийн хэрэг эд нар яваад л байдаг, яаж тэгэхдээ хохирлыг нь яах юм бэ гэдэг нэг асуудал дэвшүүллээ шүү дээ. Хууль зүйн яам хэдэн номер вэ? 2 номерын микрофон.

Б.Батболд: Сайн байцгаана уу? Ажлын хэсгийн гишүүн, ШШГЕГ-ын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, хурандаа Батболд байна. Одоогоор манай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад яг барилгын захиалгатай холбоотой дампуурлын хэрэг үүссэн гүйцэтгэх баримт бичиг байхгүй. Гэхдээ ер нь бол энэ асуултын хүрээнд хариулахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ШШГБ дээр шүүхийн албадан гүйцэтгэх захирамж ирсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1 дэх арга хэмжээг шүүхээс баталгаажуулах арга хэмжээг нэхэмжлэгч маань аваагүйгээс болоод нийт ирж байгаа шүүхийн шийдвэрийн 90 гаруй хувь нь төлбөр төлөгчийн хөрөнгө хамгаалаагүй ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл төлбөр төлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 3 шатны шүүх дээр энэ нэхэмжлэлд өөрийнхөө хөрөнгийг бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор.../минут дуусав/

О.Номинчимэг: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Батболд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29.1.7 дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу шүүхээс дампуурлын хэрэг үүсгээд дампуурсан тохиолдолд энэ ажиллагаа дуусгавар болдог байгаа. Ийм зохицуулалттай байгаа.

О.Номинчимэг: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрөөс хариуцдаг. Энэ бол ХЗДХ-ийн сайдын багцаас шүүхийн шийдвэр гараад, төрөөс барагдуулах ёстой гэсэн энэ шүүхийн шийдвэрүүдийг би хэрэгжүүлж явдаг. Гишүүдийн асуугаад байгаа асуулт бол энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яаж барагдуулах вэ, ингээд хохироод өнгөрөх үү гэдэг асуулт байгаа юм. Өчигдөр Монгол Улсын ЗГ-аас Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцээд УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Энэ дотор гэмт хэргийн улмаас, гэрч, хохирогчийг хамгаалах сангийн асуудлыг ер нь байгуулах ёстой юм байна гэж оруулж ирж байгаа сан. Энийг ЗГ-ын Тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад тусгай сан байгуулах, тэрнээсээ хохирлыг нь барагдуулдаг байя гэдэг ийм үзэл баримтлалыг ЗГ оруулж ирж байгаа. Гэхдээ.../минут дуусав/

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Түрүүн хэлж байх шиг байна. Бат-Амгалан сайд ярьж байсан. Энэ Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийн хүрээнд ТОСК, НОСК болон орон сууцжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллагын чиг үүргийг

нэгтгээд, Үндэсний орон сууцжуулалтын корпорац байгуулна гэж мэдэгдсэн. Тэгээд энэ ТОСК, НОСК, Улаанбаатар орон сууцны менежмент гээд энэ байгууллагын чиг үүргүүдийг нэгтгээд явахаар магадгүй энэ ТОСК, НОСК-ийн хэрэгжүүлж байгаа түрээсийн орон сууц, түрээслээд өмчлөх болон бусад хөтөлбөрт хамрагдсан иргэдийн гэрээ, төлбөр, өмчлөх эрхийн асуудал шинэ корпорац руу хэрхэн шилжих вэ гэдгийг урьдчилсан байдлаар тодорхой болгох шаардлагатай болов уу гэж бодож байгаа. Тэгээд энэ хууль үнэхээр яг хэрэгжээд энэ байгууллагуудыг нэгтгэх процесс явагдахаар байгаа юу? Энийг ЗГХЭГ юу гэж үзэж, харж байгаа вэ? Урьдчилсан байдлаар ямар арга хэмжээнүүдийг авч олон нийт, иргэдэд мэдээлэл хийх ёстой вэ гэдгийг асууя. Баярлалаа.

О.Номинчимэг: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудал байгаа, тэгэхдээ би ЗГ-ын хуралдаанд хэлэлцэгдсэн хүрээнд мэдээллийг өгөхөд энэ Барилгын тухай хуулийг ЗГ-ын хуралдаанаар нэг удаа хэлэлцсэн, УИХ-д хараахан өргөн бариагүй байгаа, зөвшөөрөл өгөгдөөгүй байгаа. Яг энэ бол хэд хэдэн үндэслэлтэй. Нэгдүгээрт, таны ярьж байгаа үндэслэлтэй холбоотой байгаа. Энэ үндэслэлээр нягтлах асуудал байна. Энийг ЗГ-ын агентлаг шинээр байгуулах уу, ЗГ бол ер нь төрийн шинэ яам, шинэ агентлаг байгуулах, шинэ төрийн өмчит компани /ТӨК/ байгуулах юмыг таслан зогсоох, ерөөсөө нэмэхгүй гэдэг ийм бодлоготой байгаа. Нэгдүгээр бодлого нь. Энэнтэй холбоотойгоор саатаж байгаа асуудал байгаа. Хоёр энэ.../минут дуусав/

О.Номинчимэг: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Б.Энхбаяр: Энэ Бат-Үүл даргыг хотын дарга байх үед эхэлсэн гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотойгоор газраа өгөөд орон сууцад орно гээд хохирчихсон хэдэн 100 иргэн байгаа. Энэ дотор миний авга эгч ч байгаа. 14 жил хохироод явж байгаа, орон сууцдаа орж чадахгүй. Энэ иргэдийн асуудлыг ер нь яах вэ гэдэг нэг талаас би хуулийн мухардал гэж хэлэхгүй, энэ Их Хурлаар орж ирэх шаардлагатай юм байгаа юм байна. Өргөдлийн байнгын хороо хэрэв энэ асуудлыг хэлэлцээд, ЗГ-т чиглэл өгөөд, чиглэл, өөрөөр хэлбэл энэ чиглэлээр бараг нэг удаагийн хууль оруулж ирэхгүй бол хуулийн хувьд ингээд гацчихаад байгаа юм. Иргэдийн тэр, тухайн иргэдийн хурал, Засаг дарга, тэр компанийн өмнөөс хариуцлагыг татвар.../минут дуусав/

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энхбаяр сайд үргэлжлүүлээд гүйцээгээд өгөөсэй гэж хүсэж байна. Яагаад гэхээр энэ 14 жилийн өмнө үүссэн энэ асуудал одоо хүртэл дуусаагүй байгаа. Энийг бид нэг тийш нь шийдэхгүй бол иргэд хохирсон хэлбэртэй, Бат-Үүл гэдэг нөхөр тэнд өөрөө гэдсээ илээд л хэвтэж байгаа шүү дээ. Тэгээд ийм асуудлууд байна. Нөгөө талдаа Барилга, хот байгуулалтын яам ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлынхаа дагуу тэр ТОСК, НОСК нэгдэхтэй холбоотой асуудлуудаа нэг мөр шийдвэрлэхгүй бол энд орон сууцны залилан яригдаж байгаа. Эргээд тэнд иргэдийн хохирол дахиад нэмэгдэх вий дээ? Гэрээ, төлбөр, шилжүүлэлттэй холбоотой харилцааг тэр даган мөрдөх журмын тухай хууль байдаг уу, ямар юм байдаг юм, тэрүүгээрээ зөв шийдэхгүй бол асуудлууд үүснэ. Хэрэв асуудал үүсэхээр байгаа бол бүр энийг хийх ч шаардлагагүй ийм байдлаар орхихоор бол, тэгээд энийг БХБЯ нэмээд хариулаад өгөөсэй гэж хүсэж байна. Энэ бол ирээдүйд үүсэх томоохон асуудлын нэг шүү. Энхбаяр сайдыг гүйцээлгэе.

О.Номинчимэг: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Тийм, бид энэ УИХ-ын бодлогын түвшинд бид нэг Нийтийн өмчийн хуулиа гаргах ёстой юм байна лээ өмчийн. Энэний дагуу ЗГ Нийтийн албаны тухай хуулийн төслийг бэлтгэчхээд байгаа. Өөрөөр хэлбэл тэр төрийг төлөөлж ард түмний өмнөөс шийдвэр гаргаж байгаа хүмүүсийн, албан хаагчдын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой хуулийг бид тодорхой болгох ёстой. Газрын багц хууль, газрыг ямар тохиолдолд, ямар үндэслэлээр төр нөхөх олговортойгоор авах вэ гэдгийг бид хуульчлах ёстой. Тухайн үед хуульгүйгээр хурал журам гаргаад, иргэдийн өмчлөлийн газрыг авчихсан байхгүй юу. Хувийн өмчийн газрыг хурал. Ингээд эндээс үүссэн эрх зүйн анхнаасаа нөгөө мордохын хазгай.../минут дуусав/

О.Номинчимэг: 1 номерын микрофон.

Э.Батболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя, Хот байгуулалтын яамнаас Батболд. ЗГ-аар хэлэлцүүлэгдээд, одоо УИХ-д хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн Орон сууцжуулалтын тухай хууль дээр Үндэсний орон сууцны корпорацыг байгуулахаар зохицуулалт хийсэн байгаа. Энэ корпорацыг бид мөн байгуулахдаа сая 7 сарын 3-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн засаглалын тухай хуультайгаа уялдуулж байгуулж байгаа. Өнөөдрийн явж байгаагаар Нийслэлийн орон сууцны корпорац маань Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулиараа аймаг, орон нутаг нь өөрөө байгуулаад тухайн салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага гэж гаргаж ирээд явж байгаа. Төрийн орон сууцны корпорац өөрөө энэ төрийн орон сууцжуулалтын үйл ажиллагааг хариуцах чиг үүрэгтэй байгууллага. Гэхдээ энэ байгууллагууд маань аль алин дээрээ ийм борлуулалтын шинжтэй үйл ажиллагаа явуулдаггүй. Нэг ёсондоо иргэдэд орон сууц зардаггүй, дээрээс нь орон сууцны захиалагчийн, Төрийн орон сууцны корпорац өөрөө орон сууцны захиалагчийн... /минут дуусав/

О.Номинчимэг: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би цаашид орон сууц захиалах иргэд бол эндээс мэдээж сургамж авч байгаа байх. Түүн дээрээ иргэдээс гадна иргэд юуг шалгах, юуг үзэж харах ёстой юм бэ гэдгээс гадна төр эндээсээ сургамж аваад, дараа дараагийн иргэд, дараа дараагийн захиалагч хохирохгүй байх ийм арга хэмжээг авч байгаа гэж ойлгож байгаа. Бидний хамгийн гол анхааранд байгаа юм юу вэ гэвэл өнгөрсөн хугацаанд хохирсон иргэдийн асуудлыг яах вэ гэдэг гол асуудал. Түүн дээрээ илүү хэдүүлээ төвлөрч манай төрийн байгууллагууд ч гэсэн түүн дээрээ тайлбараа өгвөл хэрэгтэй. Мэдээж эрүүгийн хэрэг үүсээд тэр гэм буруутай этгээдүүд нь энэ нэг юм шүүхээр шийдэгдээд явах байх. Гэхдээ хохирлын асуудал барагдах ямар боломж байна, ямар хувилбарууд байна, тэрийг ярьж байгаа юу гэдэг дээр илүү төвлөрч хариулт авмаар байгаа юм. Жишээ нь, зөвшөөрөлгүй барилга барьчихсан барилгын компанийн тэр барилгыг нь яах юм, ямар гарц, гаргалгаа байгаа юм, юун дээр гацаад байгаа юм нэг дэх нь?

Дахин төлөвлөлттэй холбоотой тэр барилга, байгууламж 10 хэдэн жилийн өмнөхийг нь яах юм, сүүлийн дахин төлөвлөлттэй холбоотой дээр нь яах юм гээд энэ чинь өөрөө дотроо хэд хэдэн төрлийн, хэд хэдэн янзын ийм маргаанууд байгаад байх шиг байна. Тэгэхээр хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах ямар боломж байна гэдэг талаас нь төрийнхөн яриад гарц, гаргалгаа байгаа юм уу, байхгүй юм уу, байхгүй бол энэ дээрээ гацаад байна, УИХ ингэх хэрэгтэй байна гээд бүр маш тодорхой яримаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр 69-ийн арга хэмжээ аваагүй ирдэг энд ерөөсөө ямар ч хамаа байхгүй шүү дээ. Битгий тэгээд А-г Б-ээр хольж хутгаад хүний толгой эргүүлээд, хохирсон

иргэн энэ Байнгын хорооны хурлыг сонсож байгаа бол миний хохирлыг барагдуулах талаар ямар гарц, гаргалгаа ярих нь вэ гэж сонсоод сууж байгаа шүү дээ. Тэгэхээр Хууль зүйн яам, Барилгын яам аль аль нь энэ дээр хариулт хэлээдхээч, ямар гарц, гаргалгаа байна, юу нь болохгүй байна гээд. Ийм тохиолдолд ингэж байгаа, ийм тохиолдолд ингэж байгаа, энийг нь ингэнэ гэсэн хэд хэдэн системээр маш тодорхой хариулт өгөөдхөөч.

О.Номинчимэг: Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Баасанжаргал гишүүнтэй санал нэг байна. УИХ дээр бид бодлогын шийдвэр гаргах гэж байгаа учраас ЗГ-ын тухайд тухайлбал энэ орон сууцны залилантай холбоотой зөвшөөрөлгүйгээр, анхнаасаа зөвшөөрөл авахгүйгээр бариад ашиглалтад ороод хохирчихсон иргэд байгаа. Энэ иргэдийн асуудлыг яах вэ гээд ЗГ-ын хуралдаан дээр хэлэлцсэн юм. ЗГ түүгээрээ энэ нэгэнт баригдаад одоо иргэд амьдарч байгаа орон сууцыг яриад байгаа шүү. Тэгэхдээ үл хөдлөхийн гэрчилгээ байхгүй, энэ иргэдийн тухайд энэ орон сууцных нь барилга барих тэр зөвшөөрлийг нь нөхөж олгох юм уу. Тэгээд тэр иргэдийг үл хөдлөх хөрөнгийнх нь гэрчилгээг нь, өмчийнх нь гэрчилгээг нь баталгаажуулах уу гэдэг хувилбар яригдсан. Тэгэхээр ЗГ энийг шийдвэр гаргаж чадахгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр Барилгын тухай хуулиар барилгын зөвшөөрлийг нөхөж гаргахыг хориглочхоод байгаа юм. Тэгэхээр энэ иргэдийн асуудлыг нэг удаагийн шинжтэй ийм хуулийн төсөл ЗГ-т өргөн барих чиглэл Байнгын хорооноос өгч болох уу, үгүй юү, өгвөл их сайн байгаа юм. Яагаад гэхээр ЗГ дээр энэ асуудлыг 2 удаа яриад, эхлээд нэг удаагийн шинжтэй хуульгүйгээр ЗГ шийдэхгүй юм байна гэдэг эхлээд нэг чиглэл гарсан. Тэгээд ингээд иргэд хохироод байх юм уу, хамгийн гол нь энэ цаана нь иргэд хохирчхоод байгаад байгаа юм. Тэгэхээр энэ иргэдийн асуудлыг хууль зөрчөөд ч хамаагүй ЗГ шийдье гэхээр болохгүй байгаад байгаа юм. Бид ЗГ-аасаа эхлээд хуулиа мөрдөх ёстой, их задгай компанийн нэр усгүйгээр зөвшөөрлийг нөхөж олго гэчихвэл би хардаад байгаа юм. Энэ дотор авлига гараад, ер нь хуульгүйгээр, зөвшөөрөлгүйгээр барилга ч барьж болдог ийм юмыг бид дэвэргэж, өөгшүүлж болохгүй.

Манайд өнгөрсөн хугацаанд барилгын салбарт бий болсон, ялангуяа газар, барилгын салбарт бий болсон зүйлийн гол углаа бол, шалтгаан бол авлига байгаа юм. Хүнд суртал байгаа юм. Нэг барилга барихын тулд энэ олон зөвшөөрлүүдийг авдаг. Нэг талаасаа энэ механизм хүнд суртал ихтэй холбоотой байх шиг байгаа юм. Нөгөө талаасаа энэ хүнд суртал, авлигыг жилийн 4 улирлын 3, 4-хөн сард нь барилга барьдаг ийм цаг агаартай улсад хувийн хэвшил чинь энэ төрийн хүнд суртал, авлигыг тойрч гарахын тулд барилгаа эхлүүлчхээд, дараа нь тэгээд учрыг нь олно доо, аргална даа гэдэг нэг ийм зүйл нь өөрөө энэ газар, барилгын салбарт бүр нутагшаад аль аль талдаа авлигажаад энэний өнгөрсөн хугацаанд гарсан гай л иргэд дээр ингэж буучхаад байгаа юм. Анхнаасаа зөвшөөрөл нь авагдаад барилгаа эхлээд түүн дээр захиалаад явдаг болсон бол иргэд ч хохирохгүй байсан, хэн ч хохирохгүй байсан. Тийм учраас энэ талд би аль аль талууд буруутай байна. Аль аль талууд буруутай байна. Энэ үүсчихсэн, хохирчихсон иргэдийн тухайд нэг удаагийн шинжтэй ийм эрх олговол ЗГ түүгээрээ шүүгээд, ажлын хэсэг гаргаад, тэр компаниудыг нь шүүж байгаад магадгүй Өргөдлийн байгын хороо, УИХ-д бүр танилцуулж байгаад компани болгоноор нь чиглэл авч болно. ЗГ, сайдыг би ингээд эргээд авлигажуулж болохгүй. Яагаад гэхээр зөвшөөрөл.../минут дуусав/

О.Номинчимэг: Нэмж хариулах уу, юу шүү дээ зөндөө л ярьж байгаа шүү дээ энийг чинь ажлын хэсэг, Байнгын хороон дээр ч дуудаж ирээд л яриад байгаа. Иргэд ингээд байгаа шүү дээ, бид хохирлоо төсвөөр ч юм уу, бусад татвар төлөгчдийн мөнгөөр барагдуулахгүй, зүгээр л энэ барилгуудыг нь яваад тэр механизм юу байдаг юм яваад өг, бид захиалсан байрандаа ормоор байна, бид бэлэн мөнгөөр хохирлоо төлүүлж авмааргүй

байна, энэ захиалсан байрандаа л орчихмоор байна. Төр хяналт хийхгүй, ингэж замбараагүй явсны горыг иргэд үүрч байгаа. Одоо тийм зохицуулалт, хяналт байхгүй явчхаад, одоо хууль ийм байна гээд байх шударга ёсонд нийцэж байна уу гэдэг асуудал байгаа. Түүн дээр гарц, гаргалгаа юу байх вэ, цөмөөрөө хайя гээд салбарын яамнуудтай зөндөө л ярьсан даа. Барилгын яам дээр 1 номер.

В.Мөнхжаргал: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хэлтсийн дарга Мөнхжаргал байна. Хохиролгүй болгох асуудал дээр тухайлсан барилгын зөвшөөрөлгүй барилгын асуудал дээр бид Зөвшөөрөл, мэдэгдлийн хууль 7 сарын 3-нд батлагдсантай холбогдуулаад барилгын ажлыг үргэлжлүүлэх, нөгөө 2021 оны 213 дугаар тогтоолыг бид хүчингүй болгох ажлыг ЗГ-ын тэмдэглэлийн дагуу хийх ёстой байгаа. Энэ хүрээнд бид энэ журам дээр заагдсан бусад харилцааг нь холбогдох хууль, дүрэм, Барилгын тухай хууль, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд тусгуулах чиглэлээр манай яаман дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Энэ журмыг хүчингүй болгохоор Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн дагуу зөвшөөрөл авдаг процесс маань явах юм нэг дүгээрт. Дахин төлөвлөлтийн.../минут дуусав/

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя 1 номер.

В.Мөнхжаргал: Дахин төлөвлөлтийн асуудал дээр ЗГ-ын тэмдэглэлийн дагуу бид эхний ээлжид 1008 орон сууц, Ногоон нуур 1008-ын орон сууцны төсөл, хөтөлбөрт олон жил орон сууц нь ашиглалтад ороогүй, газраа чөлөөлсөн иргэдийг оруулах ажлыг зохион байгуулаад нийслэлтэйгээ хамтраад бид эхний ээлжийн төслүүдийн тулгалтын ажлуудыг хийгдэж байгаа. Дахиж ийм зөрчил гарахгүй байх үүднээс бид Улсын бүртгэлийн газар дээр урьдчилсан тэмдэглэгээ хийдэг байх зохицуулалтыг ХЗДХ-ийн сайдын 206 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаад энэ техникийн боломжуудыг бүрдүүлээд, шинээр барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авсан барилгууд давхрын зохион байгуулалтын зургаа оруулаад захиалга өгсөн иргэд энэ дээр урьдчилсан тэмдэглэгээ хийлгээд, давхар зарах энэ асуудлыг шийдвэрлэхээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж.../минут дуусав/

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Миний асуугаад байгаа юм энэ шүү дээ. Барилгын зөвшөөрөлгүй эхэлсэн барилгын хувьд ингээд гацчихсан юм байна. Зөвшөөрлийг нь нөхөж өгөх үү, яах вэ гэж ярьж байгаа юм байна. Зөвшөөрлийг нь нөхөж өгөхөөр бол бараг УИХ Барилгын тухай хуульд өөрчлөлт орох юм байна, зөв үү? Нэг дэх гаргачихсан нь тэр байгаа юм байна.

Хоёр дахь нь дахин төлөвлөлт тэр Ногоон нууртай холбоотой 1080 айл гэсэн үү, тэрний асуудал шалгаад, чеклээд /check/ түрүүчээс нь орон сууцад нь оруулах гэж байгаа юм байна, зөв үү? Хоёр дахь нь.

Дахиад, дахин төлөвлөлттэй холбоотой хэчнээн айл байгаа юм, ямар, ямар төслүүд дээр, ямар, ямар гомдлууд байгаа юм, тэрийг яах юм бэ? Ногоон нуурыг л ганцхан ярьсан шүү дээ дахин төлөвлөлттэй холбоотой. 3 дахь тэр бусад дахин төлөвлөлтийг яах юм бэ? Дээрээс нь үнэхээр эдийн засгийн асуудлаас болоод, эдийн засгийн хүндрэлээс болоод, эсхүл барилга, байгууламжаа зөв тооцоолоогүйгээс болоод барилгаа барьж чадахгүй байгаа тэр компаниудын хохирогчдыг, захиалагчдыг яах юм, барилгыг нь өөр тийш нь шилжүүлэх, гэрээ, хэлэлцээр хийх гээд ийм өөр гарц, гаргалгаа байна уу?

О.Номинчимэг: 1 номерын микрофон.

В.Мөнхжаргал: 2026 оны 10 сарын 28-ны ЗГ-ын хуралдааны тэмдэглэлд газраа чөлөөлөөд орон сууц нь ашиглалтад ороогүй иргэдийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны төсөл, хөтөлбөрт үе шаттай хамрагдуулах чиглэлээр үүрэг, даалгавар манай сайдад өгөгдсөн. Энэ хүрээнд сая Батболд даргын хэлдгээр нийслэлээс урьдчилсан байдлаар 735 иргэдийн асуудал байгаа. Арваад жилийн өмнөөс газраа чөлөөлөөд орон сууцад ороогүй гэсэн. Энэ төслүүд дээр үе шатай оруулахаар, төрөөс хэрэгжүүлж байгаа төслүүдэд үе шаттай оруулахаар хэрэгжиж байгаа. Эхний ээлжид БЗД-ийн 30 дугаар хороон дээр хэрэгжиж байгаа төслийг, Мамба дацан хийд орчмын дахин төлөвлөлтийн төсөлд хохирсон иргэдийг 1008 руу оруулна. 2 дугаар ээлжид ЗГ-ын саяын тэмдэглэлийн танилцуулга дээр Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороон дээр явагдаж байгаа дахин төлөвлөлтийн асуудлыг оруулсан байгаа. Энийг.../минут дуусав/

О.Номинчимэг: 1 номерын микрофон тодруулъя.

В.Мөнхжаргал: Яг түр зуур уу, газрыг байраар солих уу гэдэг асуудал яаман дээр судлагдаж байгаа. Саяын БЗД-ийн төсөл дээр иргэдийг, чөлөөлсөн иргэдийг орон сууцаар солих энэ нөхцөл дээр нь судалгаа хийгдээд ажиллаж байна. Солонго 1, 2 төслийг ЗГ-аас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу арилжааны банкнуудтай сонгон шалгаруулалтыг энэ улсын төсөв батлагдсаны дараа зохион байгуулахаар үүрэг, чиглэл өгөгдсөн. Энэ хүрээнд иргэдийг оруулах ЗГ-ын 26 оны 81 дүгээр тогтоолын дагуу иргэдийг оруулах ажлаа зохион байгуулах хүрээндээ энэ ондоо багтааж бид судалж, шийдвэрлэхээр, энэ оны, энэ ондоо судлаад, ирэх оны эхний улиралд судалж шийдвэрлэхээр ажиллаж байна. Солонго 1, 2 төслийн хувьд, иргэдийг дахин төлөвлөлт.../минут дуусав/

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Номинчимэг даргад хэлэхэд манай Байнгын хороо юу яаж авъя даа энэ хэдээс аягүй тодорхой байгаа байхгүй юу. Солонго 1 хороололд төчнөөн өрхийн, тэр, тэр хохирлын, Ногоон нуурын тийм, тийм өрхийн тэр төслийн тэр айлуудыг тийм хугацаанд оруулна нэг. Тэр 730 хэдэн айлын 300-гийн тэр, тэр төслийн, тийм, тийм улмаас хохирсон айлуудын тэрийг нь тэр лүү оруулна, энэ энийг нь ийм хугацаанд оруулна гээд ганцхан хуудас, 1, 2, 3-хан өгөгдөл дээр мэдээллээ зоогоод ир гэдэг тийм үүрэг, даалгаврыг өгөөд, бүх Өргөдлийн байнгын хорооны гишүүддээ энийг тараагаад, тэгээд энийг бүр маш тодорхой шийдвэр гаргаад, Байнгын хорооноос болохгүй бол тогтоол гаргаад явъя нэг дэх нь тийм байна.

2 дахь нь энэ зөвшөөрөлгүй баригдсан барилга гээд байгаа, энэ дахин төлөвлөлтийн асуудлын улмаас хохирсон иргэд гээд байгаагийн ард дандаа төрийн албан хаагчид байгаа. Тэдний хариуцлага хаана байгаа юм, тэрний хяналт хаана байгаа юм, тэрний төлөө хэн хариуцлага хүлээх.../минут дуусав/

О.Номинчимэг: Санал хэллээ. Би энэ ЗГ-ын хурлуудаар орж байгаа тогтоолуудыг бүгдийг нь анхааралтай харж байгаа. Ерөнхийдөө дахин төлөвлөлт буюу төр 3 талт болоод нийслэл нэг тал нь болоод орчихсон юмнууд дээрээ ЗГ илүү анхааралтай, тэгэхээс ч өөр аргагүй тийм ээ, төр өөрөө дэд бүтцийг нь татна, энэ тэр гээд үүрэг хүлээчихсэн байгаа болохоор энэ дээрээ шийдлээ үе шат, дараатай хийгээд явж байгаа гэж харж байгаа, ЗГ-ын түвшиндээ. Энэнийх нь дагуу тэр түрүүн хэлж байгаа зөвшөөрөлгүй барилгаа яах вэ гэдэг шийдлүүд уг нь гарч байгаа. Гэхдээ яг хэрэгжилт дээрээ үнэхээр гацаад байгаа юм байвал бид УИХ дээр, Байнгын хороон дээр бодлогын түвшний шийдэл дээр нь хамтарч

ажиллаж болно шүү дээ. Өмнө нь тогтоолын хэрэгжилт дээр ч гэсэн уг нь өгсөн. Би тэрийг тусад нь өөрөө гишүүнийхээ хувиар асууя гэж бодож байна. Ойлголоо, дараа нь юу яасан, мэдээлэл авах гэсэн юмнуудыг ЗГ луу явуулж мэдээллийг нь авъя. Сонгобайн Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ залилан гээд бараг 36 жил явсан уу? Бүх салбар хээл хахуульд автсан, хахууль авахгүй албан байгууллага гэж байхгүй, ямар нэг асуудалд орохоор бүгд хахуулиар, тэгээд сүүлд ийм хууль бус зүйл хийгдээд залилан болоод явж байна. Хэдэн асуулт асуумаар байна л даа. Энэ орон сууцны асуудлыг холбогдож байгаа, орон сууцны залилангийн асуудалд холбогдож байгаа ААН-үүд, компаниуд одоо хэдэн компани байгаа, ямар арга хэмжээ авсныг яг тодорхой хэлж өгөөч?

Дараа нь, дахиад иргэд хохирохгүй гэсэн баталгаа байна уу? Ер нь ард түмэн хохирсны дараа, иргэд хохирсны дараа биш, урьдчилан сэргийлэх боломж байдаг уу манай улсад, манай тэр барилгын салбарт? Хохирсон иргэдийн хохирлыг яаж барагдуулах гэж байна? Дээрээс нь дахин тэр 700 хэдэн айлыг орон сууцтай болгоно гээд байна шүү дээ. Дэс дараатай, шат дараалан, тэрний санхүүжилтийг хэн хариуцах юм, хаанаас гаргах юм бэ? Энэ хэдэн асуулт асуумаар байна. Дараа нь тодруулъя.

О.Номинчимэг: 3 номерын микрофон, дараа нь 4 номер юм байна. Эхлээд 3 номер.

Н.Мишигдорж: Гишүүний асуултад хариулъя. Анх энэ ажлын хэсэг байгуулагдаад 7 сарын 21-нээс хойш 86 хуулийн этгээдэд холбогдох 2208 хохирогчтой 173 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан. ААН нь 86. Одоогоор 120 хэргийг нь шийдвэрлээд, 53 хэргийн үлдэгдэлтэй байгаа. Цагдаагийн байгууллагаас иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх дээр онцгой анхаарч байгаа. Энэ нөхөн төлүүлэх ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хүрээнд явуулж байгаа. Энэ хугацаанд нийтдээ 5.9 тэрбум төгрөгийн хохирлыг 102 иргэнд нөхөн төлүүлсэн. 170 үл хөдлөх хөрөнгийг битүүмжилсэн, 11 хөдлөх хөрөнгө буюу тээврийн хэрэгслийг мөн битүүмжилсэн, 28 дансанд хязгаарлалт тогтоочихсон. Нуугдмал хөрөнгө олох чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулаад явж байна. Нуугдмал хөрөнгийг тухайн сэжигтэн, яллагдагчийн хамаарал бүхий этгээд, бусад хуулийн хүрээнд хууль заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа. Хамаагүй дэлгэрэнгүй мэдээллийг өгөх гэхээр прокурорын зөвшөөрөлгүй болохоор өгөх боломжгүй байна.

Хохирол нөхөн төлүүлэх асуудал бол үнэхээрийн онцгой анхаарах асуудлын нэг нь мөн үү гэвэл мөн. Хэрэг шийдвэрлэхээсээ илүү хохирол нөхөн төлүүлэх асуудалд онцгой анхаарч байгаа цагдаагийн байгууллага. Энэ татан төвлөрүүлсэн мөнгөнүүд ер нь хаашаа юу болоод орчхов, яагаад барилга баригдаж дуусахгүй байна гэдэг асуудал байгаа юм. Энэ үүднээс бид аудитын дүгнэлт, шинжээчийн дүгнэлт гаргуулахаар энэ хэргүүд дээр ажиллаад өнөөдөр яг шинжээч нартайгаа уулзаад сууж байгаа юм. 3 дахь асуултыг нь яамнаас хариулна.

О.Номинчимэг: 4 номер уу? Нэрээ хэлээд, гишүүний асуултад хариулъя.

О.Цолмон: Өдрийн мэнд хүргэе. ХЗДХЯ Цолмон, гишүүний асуултад хариулъя. Орон сууц захиалах захиалагчдын эрхийг хамгаалах чиглэлээр өнгөрөгч ЗГ-ын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ дээр ямар асуудлыг зохицуулж байгаа вэ гэхээр сууц, талбайг давхардалгүй кю-ар код /QR code/ олгож, ирээдүйд үүсэх өмчлөх эрхийг нь хамгаалах чиглэлээр холбогдох хуулийн

төслийг боловсруулаад, УИХ-д түрүүчийн долоо хоногт өргөн мэдүүлсэн байгаа ХЗДХЯ-наас. Хажуугаар нь Монгол Улсын ЗГ-ын 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 406 дугаар тогтоолыг баталсан байгаа. Энэ дээр Орон сууцны залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай гэсэн тогтоол, энэ дээр ямар үйл ажиллагаа, зохион байгуулалтын арга хэмжээ авагдаж байгаа вэ гэхээр саяын хуулийн төсөлтэй зохицуулахаар тусгасан харилцааг техникийн боломж, бололцооны хүрээнд мэдээллийн технологийн арга хэрэгслийг ашиглаад давхардалгүйгээр барилгын зөвшөөрөл олгогдсон орон сууцуудыг нийтэд нээлттэй байдлаар өгөгдөл хэлбэрээр.../минут дуусав/

О.Номинчимэг: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Сая нөгөө хохирсон иргэдийг 700 хэдэн айл гэсэн үү, тэр айлуудыг үе шаттайгаар орон сууцтай болгоно гээд яриад байна шүү дээ. Тэрний санхүүжилтийг нь хэн, яаж гаргаж байгаа юм, хаанаас гарч байгаа юм бэ?

О.Номинчимэг: Дахин төлөвлөлттэй холбоотой 1 номер хариулъя.

В.Мөнхжаргал: Замира гишүүний асуултад хариулъя. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин барилгажуулах төсөл дээр 3 талт гэрээ байгуулдаг. Энэ 3 талт гэрээгээр иргэд газраа чөлөөлсөн байдаг, нэг ёсондоо мөнгөн дүн гэхээсээ илүүтэй хөрөнгөө чөлөөлж, газраа чөлөөлж газар дээр нь төсөл хэрэгжүүлэх боломжийг олгосон байдаг. Тэгэхээр яг энэ саяын 730 гаруй иргэдийн хувьд нийслэлээс төсөл хэрэгжүүлэгчийг НЗД-ын захирамжаар батламжилсан байдаг. Нэг ёсондоо иргэдээс бодитоор мөнгөн дүнгээр хохирол гараагүй, газраа чөлөөлчихсөн, эргээд тэр чөлөөлсөн газрынхаа оронд орон сууцад орох 3 талт гэрээтэй байдгийн дагуу тэр төслийн хэрэгжүүлэгчийг ТОСК дээр шилжүүлээд, дараагийн төслийг Төрийн орон сууцны корпорацаас ч юм уу зохион байгуулаад иргэд баригдсан орон сууц дээр орох асуудал яригдана.

О.Номинчимэг: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Энэ орон сууцны хохирогчдын асуудлыг Өргөдлийн байнгын хороон дээр ирээд бараг хагас жил болж байгаа байх, ингэж ярьж, ярьж эцсийн дүгнэлтээр тэр нэг удаагийн хууль гэдэг юмыг бүгдээрээ санаачилъя. Ийм л бодолтой байна. Саяын тэр дахин төлөвлөлт 10 гаруй жил болсон айлуудыг энэ мянга хэд ч билээ, энэ төрийн орон сууцад оруулах юм байна гээд түрүүн ярьж байсан, одоо түр зуур байлгах маягийн юм руу ороод явчихлаа. Түр зуур байлгаж байгаад нөгөөх нь дуусахаар олгоно гээд. Гэтэл энэ орон сууц гэдэг чинь хүний хөрөнгө шүү дээ, 10 хэдэн жил төрийн баталгаатай дайчилгаа маягаар дахин төлөвлөлтөд оруулаад баталгаа өгөөд хаячихсан, хохирчихсон. Хүний хөрөнгө учраас тэрийг чинь зарна, түрээсэлнэ, барьцаанд тавина, амьдрал ахуйдаа хэрэглэнэ, сургалтын төлбөрт хэрэглэнэ, эрүүл мэндийн эмчилгээндээ хэрэглэнэ, үр хүүхдүүддээ мөнгө, төгрөгийг нь шийдэж өгнө. Энэ бүх юмнууд нь 10 хэдэн жил гацаад нам зогсчихсон байдаг. Одоо тэр эрх нь дахиад нээгдэхгүй, дахиад нэг юм дотор түр зуур байлгах асуудал ярьж байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ эрхүүдийг нь нээж өгөх хэрэгтэй байна.

Түрүүчийн хурал дээр Энхбаяр сайд, Бат-Амгалан сайд 2 энэ талд сууж байсан даа, тэр талд суучхаад нэг удаагийн хууль хэрэггүй, одоо ЗГ-ын хуралдаанаар оруулаад шийдэх гэж байгаа гээд яриад байсан шүү дээ. Тэгээд шийдэх асуудлыг хурдхан шийдчихмээр байх юм. Энд түр зуур гэж юугаа яриад байгаа юм, би бүр ойлгохоо болилоо. Цаана нь энэ хүмүүс чинь амьдрал ахуйдаа нөгөөхөө зарцуулмаар байдаг, амьдрал нь дууслаа шүү дээ, одоо ингээд 20 жил боллоо. Заримынх нь угаасаа дуусчихсан байгаа,

ийм асуудал дээр их тайван байна. Тийм болохоор тэр нэг удаагийн хууль гэдэг зүйлийг оруулах нь зөв юм байна, тэгэхгүй бол ингээд за өгөх гэхээр зэрэг эрх зүйн орчин байхгүй, татвар төлөгчдийн мөнгөөр өөр хүний хохирлыг яаж шийдэх юм гээд байх юм. Энэ 1 дүгээрт тэнд чинь төрийн баталгаа өгчихсөн, 2 дугаарт нь энэ засаг чинь татвар хураагаад, төрийн үйлчилгээ үзүүлдэг биш болчихсон шүү дээ. Ашиг олдог байгууллага болчихсон, төрийн өмчийн компаниуд баахан ашиг олдог, баахан барилга барьдаг. Татвар төлөгчдийн мөнгөөр ашиггүй төслүүд хийгээд барилгууд бариад, алдагдлыг нь төсвөөс нөхөж байгаа шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгөөр төрийн албан хаагчдад янз бүрийн орон сууцны хөтөлбөр /program/ явуулж байгаа. Тэгээд хэнийх нь асуудлыг шийдэхээр татвар төлөгчдийн мөнгөөр яаж шийдэх юм гээд байдаг, хэнийх нь болоод байдаг юм, яс юман дээр энэ ялгаварлан гадуурхалт шүү. Нэгэнт төр үүрэг хүлээгээд баталгаа өгсөн бол, дайчилгааны маягаар ийм асуудал хийсэн бол энийгээ хариуцаад хийх хэрэгтэй. Тийм болохоор энэ дахин төлөвлөлтийн нэг асуудал байна, дээрээс нь тэр дэд бүтцийн асуудлууд хийгдээгүй. Тэгээд залилан яаж шийдэх юм, ямар хэмжээний мөнгө байх юм. Нэг удаагийн хууль гэдэг юмыг бүгдээрээ санаачилъя, ийм саналтай байна.

О.Номинчимэг: Золжаргал гишүүн санал хэллээ. Би хэдэн зүйл тодруулъя, энэ ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд. Урьдчилан сэргийлэх, дахиж ийм юм гарахгүй байх дээр ЗГ хангалттай сайн ажиллаад энэ журмуудаа, хуулиудаа өргөн барьж байгаа. Гэхдээ тэр Орон сууцны хууль дээр байна, уг нь Барилгын тухай хууль дээр л байх ёстой байгаад байдаг юм. Энэ барилга барьж байгаа этгээд, борлуулалт хийж байгаа этгээд 2-ыг салгахгүй бол энэ хариуцлагагүй, хариуцлагаас зугтсан асуудал бүрэн утгаараа шийдэгдэхгүй. Зах зээлийн зарчим нь уг нь тийм байхгүй юу. Тэгээд эскроу данс /escrow account/ гэдэг шийдэл орж ирчхээд байгаа юм байна, хэр зөв юм, санхүүгийн тэр санхүүжилтийнх нь юм дээр тэр нь хэр зөв орж ирж байгааг бид харах ёстой байх. Тэр Барилгын тухай хуулиа сайн, хурдан хийж 1 дүгээрт оруулж ирмээр байна.

2 дугаарт бид энэ ажлын хэсгийг байгуулаад нэлээн олон ийм хохирогч иргэд байна, бидэнд ч гэсэн олон ийм өргөдөл ирлээ. Бид Өргөдлийн байнгын хороон дээр ямар ч байсан 2 зарчим барьж ажиллая гэж Байнгын хорооны гишүүдээрээ тохирсон. 1 дүгээрт, энэ асуудлыг улс төржүүлэхгүй, хэн нэгэн барилгын компани, хэн нэгэн улс төрчтэй холбоотой байгаа, тэрийг нь юу гэдэг юм босгож ирэх ч юм уу ийм асуудал байхгүй. Энэ бол иргэдийн хохирлыг барагдуулах, цаашид дахиж ийм юм гарахгүй байх дээр цөмөөрөө анхаарна. Улс төржихгүй. 2 дугаарт шууд юу гэдэг юм төсвөөс ийм хохирлыг нь барагдуул гэдэг шийдэл рүү явахгүй. Ингээд явахаар үеийн үед хохироосон иргэн тэндээ манай Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаагаар гэдсээ илээд хэвтээд хожоод гардаг, ийм даамжирсан хариуцлагагүй явдал ингээд дараа дараадаа санамж болохгүй байдаг учраас аль болох аж ахуйн тэр deal хийдэг юм уу, хэлэлцээр хийдэг юм уу, аль болох тэр ЗГ-ын гүйцэтгэх level дээрээ энийгээ сайн шийдээд шийдлүүд гарчих боломж байна гэж харж энэ асуудлыг гаргаж ирсэн.

Одоо явц явж байна, зарим тал дээр ахиц дэвшил гарч байгаа, энийг нь хэлэх хэрэгтэй. Ялангуяа дахин төлөвлөлтийн асуудал дээр нийслэл, төр өөрөө оролцсон асуудал дээр шийдлүүдээ гаргаж байгаа юм байна. Тэгээд энэ нарийвчилсан мэдээллүүдийг нь авъя. УИХ-аас тогтоол гаргасан, Өргөдлийн байнгын хороо 2026 оны 7 сарын 2-нд 53 дугаар тогтоол дээр яг энэ тогтоолын 4 дүгээрт, би энийг өмнөх энэ тогтоолын хэрэгжилтийн хэлэлцүүлэг дээр ч гэсэн хэлж байсан, баригдаж дуусаагүй болон удаан хугацаанд зогссон орон сууцны барилгад иж бүрэн үнэлгээ, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, төслийг үргэлжлүүлэхэд шаардагдах зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх замаар төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх гэсэн ийм чиглэл өгсөн юм. Гол

асуудал энэ дээр л удчихаад байна. Манайд дахин, дахин ирж байгаа өргөдлүүд бол нөгөө дахин төлөвлөлт ирж байгаа, эхнээсээ шийдэгдэж байгаа юм байна. Дахин төлөвлөлт биш хувь компаниуд зөвшөөрөлгүй баахан барилга эхлүүлээд, тэгээд иргэдээс баахан мөнгө цуглуулаад, одоо тэр нь санхүүгийн чадавх нь байхгүй юм уу, эсхүл зөвшөөрөл нь байхгүй гацчихаад байгаа, иргэд нь орон сууцдаа оръё гэхээр явахгүй байгаа асуудал энэ Марч констракшн юу, юу билээ, нэлээн олон төслүүд байгаа. Энийг яах гэж байна вэ гэсэн Зөвшөөрлийн хуулийнхаа дагуу Засгаар тогтоол оруулаад болчихно гэсэн. Тэгэхээр би одоо тодорхой нэг юм асуумаар байна.

Нэгдүгээрт, яг энэ зөвшөөрлийн та бүхний ЗГ-аар оруулж, тогтоолоор оруулж шийд өгсөн энэ зөвшөөрлийн дагуу хуулийнх нь дагуу энэ биднээс очсон бүх өргөдөл чинь шийдэгдэх юм уу, шийдэхгүй юм уу, түүн дээр тийм, үгүй гээд маш тодорхой хэлчихмээр байна. Үнэхээр шийдэгдэхгүй байх юм бол бид тэгвэл хууль, эрх зүйн орчин юуг, яах ёстой гэдгээ яримаар байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт, Энхбаяр сайдын хэлж байгаа үнэн. Бид яг үнэхээр энэ хохирсон л иргэдийнхээ асуудлыг бодохгүй бол нэг удаагийн хууль байдаг юм уу, нэг удаагийн ийм юмаар дундуур нь нөгөө нэг завших гээд орж ирж байгаа нөхдүүд орж ирдэг. Нөгөө ямар ч юу гэдэг юм танил тал юутай, зөвшөөрөлгүй барилга байгууламж эхэлчхээд энийг дагуулаад өөрсдийнхөө юмыг зүй ёсны болгоод авъя гээд анхнаасаа хууль зөрчөөд. Энэ цаашдаа ингээд даамжирдаг юм байдаг. Над дээр бас, бидэн дээр мэдээлэл ирж байгаа. Ийм юм яригдаж байгаа юм байна, нийслэл дээр тэгвэл лист гаргаж байгаа юм байна, тэрэнд нь энийг оруулчихъя, тэрийг нь оруулчихъя гэдэг юм яваад эхэллээ гэдэг юм бас сонсогдож байгаа байхгүй юу. Ингэх юм бол дахиад шударга ёс гэдэг чинь байхгүй болно. Хууль тогтоомжоор далимдуулаад хэн нэгэн нь хожоод, ядарсан муу хэдэн иргэдийнхээ хүсэл зориг дээр дөрөөлж байгаад хэдэн эрх дархтай, тэнд авлига аваад янз бүрээр эхэлсэн барилгын хэдэн эзэн байдаг юм уу, эрх бүхий албан тушаалтнуудтайгаа үгсэж байгаад ингэсэн ийм юм хожоод үлдэж болохгүй гэдэг ийм зарчим байгаа. Тэгэхээр 1 дүгээр асуудал тэр зөвшөөрөлтэй холбоотой та бүхэн яг Зөвшөөрлийн хуулиараа энийгээ бүрэн энэ асуудлуудаа шийдэж чадаж байгаа юм уу, үгүй юм уу энэ дээр нэг хариулт өгөөд?

2 дугаарт, яг энэ асуудал дээр тэгээд хариуцлага алдсан, хяналт шалгалт хийж байх ёстой үүрэгтэй байсан юу гэдэг юм бүх шатад нь юмаа ухвал гарч ирнэ дээ. Энэ төрийн албан тушаалтнууд, албан хаагчдад ямар хариуцлага тооцож байгаа юм, тэн дээр хийж байгаа юм байна уу гэдэг энэ 2 асуулт дээр хариулт авъя. Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Зөвшөөрөлгүйгээр барилга бариад, тэгээд иргэд орчихсон энэ тохиолдол дээр нөхөж зөвшөөрөл өгөхтэй холбоотой асуудал ЗГ дээр 2 удаа яригдсан. ЗГ-ын нэгдсэн би байр суурийг төлөөлөх ёстой, нэгдсэн байр суурьд хүрээгүй. Яагаад гэхээр Барилгын сайд болон нийслэл Улаанбаатар хот, энэ чинь ганцхан Улаанбаатар хотод байгаа биш, аймгуудад бас байгаад байгаа юм. Энэ нийт орон сууцтай холбоотой судалгаа бол гарчихсан байгаа. Барилгын яам болон Улаанбаатар хотын түвшинд гарчихсан. Энэ дээр өөрсдөө бас ажиллачихсан, энийг шууд ингээд харанхуй энэ зөвшөөрлийг нь олгох эрхийг хотын дарга болон Барилгын сайдад ЗГ өгөхгүй гэдэг байр суурьтай байгаа. Би Хэрэг эрхлэхийн сайдын хувьд. Яг саяын үндэслэлээр, энэ цаана нь юу байгаа юм авлигууд байгаа юм уу, зөвшөөрөлгүй барьчхаад ийм юмыг дэлгэрүүлчих юм биш байгаа. Хуульгүйгээр амьдарч сурна гэдэг хэв маягийг өөгшүүлж болохгүй, хууль саад болоод байвал хуулиа боловсронгуй болгож явах ёстой. Тийм учраас энэ асуудлыг ингэж харанхуй нөхөж олгохгүй, энэ хууль зөрчинө гэдэг байр суурийг би Хэрэг эрхлэхийн сайдын хувьд барьж байгаа. Яагаад гэвэл ЗГ хэлэлцэж байгаа асуудал болон гарч байгаа шийдвэр бол

Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжийн хүрээнд гарах ёстой, түүнийг зөрчиж гарах ёсгүй гэдэг манаачийн ажил хийж байгаа учраас энэ байр суурь дээр байгаа. Тийм учраас энэ асуудал ЗГ-ын хурал дээр шийдэгдэхгүй байгаа.

Харин нэг удаагийн шинжтэй гэдэг нь юу яриад байна вэ гэвэл яг ийм тодорхой асуудлууд болж өгвөл уг нь компаниа болгоноороо танилцагдаад, УИХ дээр шийдвэр гаргачихвал ЗГ-т мөн их амар байна. Өөрөөр хэлбэл ЗГ таны хэлж байгаачлан Улаанбаатар хотын түвшинд, тэр яамнуудын түвшинд дунд, доод шатанд авлига авч тэнд юм шургуулж, зөвшөөрлийг нь нөхөж олгох вий гэдэг болгоомжлол танд ч байна, надад ч байна. Тийм ч учраас ЗГ шийдэхгүй байгаа юм. Хэрэв шийдэх гэж байгаа тохиолдолд хуулийн хүрээнд буюу УИХ-аас нэг удаагийн шинжтэй эрх олгоод, ЗГ өөрөө тал талын оролцоо, УИХ-ын хяналттайгаар энийг тэр иргэдийн эрх ашиг, гарцаагүй шалтгаан байсан байна уу, давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн байна уу гэдгийг тодорхой болгож байж шийдэхгүй бол бид бас шүүхийн шийдвэр давж чадахгүй.

Өнөөдөр жишээлбэл энэ авлига хороололтой холбоотой Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэр гарсан гэдэг мэдээлэл цахим орчинд явж байна. Хэрэв энэ үнэхээр үнэн бодитой бол ЗГ Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэрийг лав давж шийдвэр гаргаж чадахгүй. Улсын Дээд шүүхийн шийдвэрийг Монгол Улсад суугаа улсын Ерөнхийлөгчөөсөө эхлээд, Ерөнхий сайдаасаа эхлээд, УИХ-ын гишүүн, иргэд хэнбугай ч заавал сахин биелүүлэх ёстой гэдэг Монгол Улсын Үндсэн хууль байгаа. Тийм учраас бид энийг давахгүй. Тийм учраас энд харин хохирч байгаа иргэдийн асуудлыг шүүхийн шийдвэрийг давж лав ЗГ шийдэж, шийдвэр гаргахгүй. Ийм байгаа юм.

О.Номинчимэг: Ийм байгаа юм Энхбаяр сайдаа, манай дээр зөвшөөрөлгүй баригдчихаад иргэд нь орчихсон асуудал дээр нэг ч өргөдөл гомдол ирээгүй. Орон сууцны залиланд өртчихсөн энэ иргэдийн асуудал ерөөсөө мөнгөө өгчхөөд захиалчхаад орон сууц нь баригдахгүй гацчихсан, эсхүл анхнаасаа залилангийн шинж чанартай юмнууд яваад байгаа юм. Тэгэхээр юун нөгөө орон сууцдаа орох, орон сууцдаа орчихсон хүмүүс чинь тодорхой хэмжээгээр барих юмтай болчхоод байдаг, манай дээр яг хамгийн тулгамдаж байгаа энэ өргөдөл ерөөсөө орон сууц нь баригдаж байгаад гацчихсан, нөгөө компаниуд нь төлбөрийн чадваргүй болчихсон юм уу, зугтаад явчихсан юм уу, яадаг юм, эсхүл зарим нь гүйцээчихмээр байна дааНч зөвшөөрөл өгөхгүй байна гэдэг юм л үлдчихээд байгаа гэж байгаа юм.

Тэгээд энийг ЗГ дээр яриад, гол нь яг түрүүний миний уншсан тогтоолын чиглэлээр яг аль барилгууд юм, манай Өргөдлийн байнгын хорооноос та бүхэнд шилжүүлсэн судлаадах гэсэн энэ барилгууд дээр яг юу болоод байгаа юм гэдгийг бүгдийг нь нарийвчлаад гаргачихвал шийдлээ ярихад ойлгомжтой байхгүй юу. Тэгэхгүй ерөнхийлөөд л орон сууц залилан гээд л ингэхээр нэгэнд нь давуу эрх өгөх гээд ч байгаа юм шиг, авлига хороололд нэгдээд байгаа ч юм шиг ийм юм байж болохгүй. Бид яг бидэнд ирсэн өргөдлийнхөө дагуу энэ дээр та нар тэр стандарт нөхцөл юу байдаг юм зөвшөөрөл нь байхгүй болоод энэ нь Зөвшөөрлийн хуулиараа шийдэгдэж болж байна уу, болохгүй байна уу гэдэг дээр нарийвчилсан тоон мэдээллээ өгөөдөх, тэгээд бид бодлогын хүрээнд дэмжиж ажиллах бол дэмжиж ажиллана. Иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахын төлөө Өргөдлийн байнгын хороо ажиллана гэдгээ хэлчхээд байгаа юм. Тэгээд тэрнээс хойш манай дээр ямар ч мэдээлэл ирэхгүй л байна л даа.

Тэгээд мэдээлэл нь ЗГ дээр бүгдээрээ байгаад байдаг, бид чинь ямар нийслэл байгаа биш, ЗГ байгаа биш тэр аж ахуйн ажил, баахан мэдээлэл УИХ-ын гишүүд мэдээж энэ чинь судлаад тэрүүгээр нь яваад байж байна гэж байхгүй шүү дээ. Бодлогын яам нь,

нийслэл нь бүх мэдээлэл нь багцлагдаад байх ёстой шүү дээ. Тэрийг нь л хянан шалгах, зөв үү, үгүй юү гэдгээ нэг харчхаад шийдлүүдээ яримаар байгаа байхгүй юу. Маш тодорхой уг нь ийм байгаад байдаг. Тэгээд энэ дээр ЗГ дараагийн шатанд анхаарааач. Бид бодлогын хүрээнд дэмжих юм байвал дэмжинэ. Гэхдээ энэ цоорхойг далимдуулж хэн нэгэн ашиг завшаан олох гэж байгаа юмыг дэмжихгүй, тэгэхээр яг яаж зөв шийдэх вэ гэдгийг та бүхэн анхан шатны суурь мэдээллүүдээ гаргаж өгсний үндсэн дээр л бид хэлэлцэнэ үү гэхээс зүв зүгээр байж байгаад бид чинь тэгье гээд нэг бланкаар нь нэг юм шийдэж чадахгүй шүү дээ. Болохгүй биз дээ, тэгээд түүн дээр анхаарааач. Тэгэхээр Байнгын хорооноос чиглэл өгөөд, та бүхнээс тэр мэдээллийг хурдан бэлтгэж өгөх тал дээр анхааръя. Тэгээд энийгээ нэг жил тойрч энэ иргэдийнхээ сэтгэлийг амраагаад нэг ийм шийдэл гарч байгаа юм байна, төр засаг нь сонсож байгаа юм байна гэдэг юм руу л үр дүн хамтдаа гаргах хэрэгтэй байна даа л гэж хэлмээр байна. Энэ багц өргөдөл ингээд хэлэлцэгдэж дууслаа. Дараа нь дахиад 10 багц байгаа шүү, гишүүдээ.

Дараагийнх, иргэн Гантуяа, Отгонбилэг, Ариунтуяа, Хүрэлбаатар, Зандраа, Цэнд-Очир, Хишигдорж, Энхсувд, Амаргэрэл, Цэрэнчимэд, Сосорбарам, Бямбачулуун нарын ахмад настнуудаас нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр шинэчлэн тогтоохдоо даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хугацаанаас хамаарч ялгаатай байхаар тогтоосноос 2013 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмадууд анх тэтгэвэр тогтоолгохдоо бодит цалингаа хязгаарлуулж тэтгэвэр тогтоолгосон бөгөөд итгэлцүүр шинэчлэн тогтоолгоход дахин хязгаарлуулж, тэтгэврийн хэмжээ нэмэгдээгүй бөгөөд уг хязгаарлалтыг бүрмөсөн зогсоох, эсхүл нэмэгдүүлэх хязгаарлалт тавихгүй, тэтгэврийг шударгаар дахин бодуулах асуудлаар, мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн, тэтгэвэр тогтоолгоход хүлээгдэж байгаа иргэдээс Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу ЗГ-ын баталсан итгэлцүүр нь өнөөгийн мөнгөний үнэ цэнд хүрэхгүй байгаа бөгөөд холбогдох төрийн байгууллагууд дээрх хуульд заасны дагуу математик үйлдэл, тооцооллыг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулаагүй зэрэг асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг нарийвчлан сонсъё. Гэр бүл, хөгжил, хүний хөгжлийн яам болон НДЕГ-аас яаж шийдсэн талаараа мэдээлэл өгөх нь байна. Хэдэн номер вэ, аль нь вэ? 8 номер.

Б.Батжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. НДЕГ-ын дарга Батжаргал. Энэ асуудалтай холбоотойгоор Өргөдлийн байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдаад, Рэгдэл гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон нийгмийн даатгалын төлөөлөл орж ажилласан. Холбогдох нэр бүхий 14 иргэний мэдээллийг нэг бүрчлэн бид шалгаж, Өргөдлийн байнгын хороонд болон ажлын хэсэгт хүргүүлсэн байгаа. Энэ асуудлын хүрээнд хамгийн эхний ээлжид 2027 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн төсөл дээр энэ ярилцсан асуудлаар 1 сая 404 мянгаар хязгаарлагдсан хэмжээг 2 сая 400 мянга болгож өсгөх тооцоолол хийгээд, үүнд шаардагдах 328 тэрбум төгрөгийн зардлыг төсвийн төсөлд тусгаж хүргүүлсэн. Энэ төсвийг бол одоо УИХ дээр хэлэлцэж байна. Хэрэв энэ төсөв батлагдвал 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлээд бүх тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчилсэн итгэлцүүрээр тооцоод, өссөн бол өссөн тэтгэврийг нь өгнө, өсөөгүй бол одоо байгаа тэтгэврийг нь өгнө гэсэн хувилбараар явж байна. Тэгээд урьдчилсан тооцооллоор 141 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр ямар нэгэн байдлаар өсөх тооцоололтойгоор ажиллаж байна.

Хоёр дахь асуудал нь энэ оны 7 дугаар сарын 2-ны өдөр УИХ-аас Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг баталсан. Энэ хуулийн хүрээнд анх удаагаа суурь тэтгэврийн тогтолцоо Монголд нэвтрээд, нийгмийн даатгалын

сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн тодотголоор 11 дүгээр сарын 1-ний өдөр 412 мянган тэтгэвэр авагч ахмад настанд 98 тэрбум, 92 тэрбум төгрөгийн суурь тэтгэврийг бид олголоо. Тэгээд одоо энэ тэтгэврийг бид 12 дугаар сарын 1, сар болгонд өгөхөөр тооцоод ажиллаж байна. Төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн төсөл дээр суурь тэтгэврийн зардалд зориулж 1.2 их наяд төгрөгийн зардал туссан байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Энэ асуудалтай холбоотой асуулт асуух, тодруулах гишүүн байна уу? 2 гишүүнээр тасаллаа. Замира гишүүн.

С.Замира: Баярлалаа. Би энэ асуудалтай ч холбоотой биш, уг нь нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-тэй холбоотой нэг асуулт асуумаар байна. Уг нь хүмүүс НДШ-ээ төлж яваад ажлаас гарах юм уу, ямар нэг завсарлага гараад нөгөө төлж байсан шимтгэл нь тэр чигээрээ байхгүй, дараа нь хэдэн сар тасалбал урьд нь төлсөн нь хүчингүй болоод байгаа шүү дээ. Ер нь энэ яагаад ингээд өөрчилсөн юм? Яагаад дахиад нөхөж хийж болохгүй гэж? Зөндөө хүн хохирч байгаа энэнээс болоод, энэ талаар асуумаар байна.

О.Номинчимэг: НДШ-тэй холбоотой асуулт, 8 номер.

Б.Батжаргал: Замира гишүүний асуултад хариулъя, НДЕГ-ын дарга Батжаргал. НДШ төлж байгаад ямар нэгэн шалтгаанаар төлөөгүй тасардаг тохиолдол амьдрал дээр бий. Энэ үед хуулиар өмнө төлсөн шимтгэлийг хүчингүй болгоно, тооцохгүй гэсэн зохицуулалт хуульд байхгүй. Бид нийт төлсөн шимтгэлийг программд нэг бүрчлэн бүртгээд явж байгаа. НДШ-ийг нөхөн төлөх тохиолдол 2023 онд УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тодорхой шалтгаануудыг нэг бүрчлэн дурдсан байгаа. Жишээлбэл, албан журмын даатгуулагч ажлаа хийж яваад хүүхдээ асрах чөлөө авсан хугацааны шимтгэлийг байгууллага хүүхдээ асрах чөлөөтэй хугацаанд төлөх хуулийн заалттай. Зарим тохиолдолд энэ орхигддог. Иргэдээ хамгаалах үүднээс энэ тохиолдолд жишээлбэл байгууллага нөхөн төлөх ийм хуулийн зохицуулалт одоо ч хүртэл хэрэгжээд явж байгаа. Жишээлбэл, гадаадад байгууллагын захиалгаар суралцах хугацаанд байгууллага төлдөг, тэгээд зарим тохиолдолд байгууллага ямар нэг шалтгаанаар энэ хүнээ мартдаг. Энэ тохиолдолд буцаагаад нөхөн төлөх хуулийн зохицуулалтууд байдаг гэдгийг хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Яг өөрийн чинь яриад байгаа энэ асуудал бол яг би өөрийн хажууд байгаа хүмүүсийн амьдралаас хараад байна л даа. 10 хэдэн жил төлж яваад дахиад нөхөж төлье гэсэн чинь тийм юм байхгүй гэж хариулт өгсөн байгаа юм. Тэгвэл энэ асуудлаар ард түмнийг нөхөж төлж болно гэсэн асуудлаар ард түмнийг мэдээллээр хангах нь зүйтэй. Яг наад хэлж байгаа үг чинь хэрэгжиж байна уу, үгүй юү гэдэг дээр дахиад нэг эргэж дүгнэлт хийгээрэй. Тэгээд албан ёсоор надад бичгээр хариу өгөөрэй. Баярлалаа.

О.Номинчимэг: Санал хэллээ. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: 36 сарын тэтгэмжид хамрагдаагүй үлдсэн ахмадуудад энэ тэтгэмжийг нөхөн олгох тухай хүсэлт Өргөдлийн байнгын хороон дээр иргэн Баделханаас ирсэн юм байна. Тэгээд энэ асуудал яг яахаар болсон бэ нэгдүгээр асуулт нь?

Хоёрдугаарт нь, төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийг үр хүүхдэд нь өвлүүлэх санал яригдаад байдаг юм, мэр сэр. Тэгээд тэр асуудал дээр Гэр бүлийн яам

болон ЗГХЭГ-ын асуудал юм байна, хамтарсан шийдвэр. Тэгэхээр энэ асуудал ямар шатандаа явж байгаа юм, энэ нь яахаар болсон юм бэ?

О.Номинчимэг: Иргэн Б-ээс ирсэн 36 сарын тэтгэмжтэй холбоотой асуудал болон тэтгэмж өвлөгдөх асуудлаар өргөдлүүд ирсэн байгаа бидэнд, Гэр бүлийн яам руу бүгдийг нь явуулсан байгаа. Хэдэн номер вэ, 7 номер юм уу, 8 номер юм уу? Эсхүл ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар байгаа байх, 7 дээр үү? Угаасаа та бүхнээс асуух гээд 72 кэйс /case/-д орчихсон байгаа шүү дээ Иргэн Б-ийн 36 сарын асуудал тэр лист дээр байгаа. 7 номер хариулах юм уу, 8 номер юм уу? 7 номер.

Н.Баярмаа: ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар Баярмаа, гишүүний асуултад хариулъя. Хоёр өргөдөл байгаа. Тэгээд ЗГХЭГ-ын даргын тушаалаар Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийг боловсруулах ажлын хэсэг гарсан байна лээ. Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр ажлын хэсэг ажиллаад, энэ асуудлыг Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд одоо тусгаад явж байгаа гэсэн энэ өргөдөл, гомдлын хариултыг өгсөн.

О.Номинчимэг: Тусгаад явж байгаа, шийдэгдэнэ гэсэн юм уу, шийдвэрлэх явцдаа байгаа гэсэн үг үү? 7 номер.

Н.Баярмаа: Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байгаа. Ажлын хэсэгтээ энэ асуудлыг бид тусгаад судлаад явж байна. Одоогийн байдлаар хууль, эрх зүйн зохицуулалтаар зохицуулах боломжгүй байна гэсэн хариултыг Гэр бүлийн яамнаас өгсөн байна. Гэр бүлийн яамны ТНБД ахалсан дэд ажлын хэсэг ЗГ дээр бас ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Өвлөгдөх асуудал адилхан уу, судлагдаж байгаа гэсэн үг үү? Энэ асуудлаар гишүүд асуулт авч дууслаа.

Дараагийн асуудал, Шинэ Улаангом худалдааны захтай холбоотой гарсан өргөдлийг шилжүүлсэн, ЗГХЭГ-ын дарга Энхбаяр сайд танилцуулгадаа шийдэл хэлсэн учраас сонссонд тооцлоо.

Дараагийнх нь, Бэрхийн уурхайн нэр бүхий иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэлээс Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хандан ирүүлсэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Монгол Улсын ЗГ-ын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, Бэрхийн уурхайн нэр бүхий 102 иргэнд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг ЗГ-т даалгасан боловч шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа талаарх өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг сонсъё. Гэр бүлийн яам, товчхон хариулчих, ерөнхийдөө чухал. 8 номер.

Ж.Энхтөр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Энхтөр байна. Бэрхийн уурхайн уурхайчдын нөхөн олговрын асуудал байгаа. Энэ асуудал яригдаад тус яамны Хөдөлмөрийн хэлтсээс 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1, 97.1.2-т заасны дагуу Бэрхийн уурхайд ажиллаж байсан нэхэмжлэгч нэр бүхий 112 иргэнд олгох нөхөн төлбөрийн хэмжээг Монгол Улсын ЗГ-ын 2023 оны итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай 238 дугаар тогтоолд заасан цалингийн итгэлцүүрийг ашиглан тооцоолоход нэг удаа олгоход 4,717,939,170 төгрөг шаардлагатай гэж тооцоолол гаргасан байгаа.

Сая Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн хэлэлцүүлгийн гуравдугаар шатны хэлэлцүүлгийн үеэр энэ Бэрхийн уурхайчдад олгох нөхөн олговрын энэ 4 тэрбум 717 сая төгрөгийн асуудлыг нэмэлт санал хураалтаар орж, гуравдугаар хэлэлцүүлэгт орсон байгаа. Ингээд маргааш Монгол Улсын 2027 оны төсөвт батлагдах юм Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр энэ төсөв батлагдана. Энийг он гарангуут холбогдох хууль, журмынх нь дагуу энэ иргэдэд нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулна.

О.Номинчимэг: Угаасаа наад төсөв чинь болохгүй байна гэсээр байгаад л Өргөдлийн байнгын хорооноос бичиг явуулж байж ажлын хэсэг дээр энэ төсвийг оруулсан л даа. Тэгээд бидний хийсэн ажил. Гэхдээ гол нь төсөв нь батлагдаад ирэхээр тэр ажлын хэсэг маань хурдан ажиллаад энэ асуудлыг шийдээд өгөөрэй. Олон жил яваад байгаа юм байна лээ шүү. Асуулт асуух, тодруулах гишүүн гайгүй байх тийм ээ? Бэрхийн уурхайн нөхөн олговор. Алга байна.

Дараагийнх нь, иргэн Д, би энэ өргөдөл гаргагчтай холбоотой мэдээллийг тэр болгон бүтэн олон нийтийн асуудал дээр хэлээд, яг хувь хүний хувьд гаргасан өргөдлүүдийг иргэнийх нь нэг үсгээр хэлж байгаа шүү. Иргэн Д-ээс Баянхонгор аймгийн Галуут суманд үйл ажиллагаа явуулж байгаа "Г" ХХК-ийн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа талбайд Монголын эзэнт гүрний үед холбогдох чулуун дараас бүхий булш, оршуулгын 14 тооны түүх, соёлын үл хөдлөх дурсгал ирүүлсэн бөгөөд байгалийн тэнцвэрт байдал, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах яаралтай арга хэмжээ авч, соёлын өвийн хамгаалалтын орчны болон хамгаалалтын бүсийг тогтоон төрийн хамгаалалтад авах талаар ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн талаар мэдээлэл сонсъё. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас өгөх үү? 8 номер.

Б.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя. Иргэн Д-гийн холбогдолтой энэ асуудлаар өнгөрсөн жил буюу 2025 онд тус яамнаас Соёлын өвийн үндэсний төв болон Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музейн захиралд үүрэг даалгавар өгч тухайн талбайд үзлэг хийсэн байгаа хуулийн дагуу. Тухайн талбайд ҮД-643400230 дугаар улсын бүртгэлд Үнэгт 3 дугаар багийн Их тойруу, Их дугуй нэртэйгээр нэг дурсгалт газрын 14 дурсгал бүртгэгдсэн байгаа. Тус дурсгалыг журмын дагуу улсын бүртгэлд бүртгэсэн байгаа. Энэхүү хүсэлтийн дагуу, өргөдөл гомдлын дагуу бид ажиллаад, 2025 оны 9 дүгээр сарын 25-нд, мөн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр соёлын өвийн улсын бүртгэлд бүртгэснээр өргөдөл, гомдлыг хааж барагдуулсан байгаа.

О.Номинчимэг: Энэ асуудалтай холбоотой асуулт асуух асуух, тодруулах гишүүн? Ер нь тэгээд үүрэг даалгавар өгөөд, хамгаалалтад авахаар ажиллаж байгаа гэж ойлгож байгаа зөв үү? Наадах чинь тэгээд уул уурхайтай холбоотой бас асуудал хөндөгдөөд, олон яамдын дунд шидэгдээд, олон сайд нарын дунд шидэгдээд байсан асуудал байх. Хэдийгээр шийдэгдэхээр байна, хуулийн дагуу л мэдээж шийднэ шүү дээ аль нэгэн талын шийдэл гэхээсээ илүү бид өргөдөл, гомдол гаргагчид нь хуулийн дагуу юм байна гэх юм уу, үгүй юм уу, та бүхэн судлаад хариугаа л гаргах ёстой шүү дээ. Хэзээгээр шийдэгдэхээр байгаа гэнэ? 8 номер.

Б.Бат-Эрдэнэ: Улсын тусгай хамгаалалтад авах зэрэглэл тогтоох ажил нь Соёлын өвийн хуулиараа шинжлэх ухааны үнэ цэн, шинжлэх ухааны хүрээлэнгээс гаргаж байгаа, шинжлэх ухааны байгууллагуудаас гаргаж байгаа үнэ цэн, ач холбогдлын дагуу ач холбогдлыг үнэлж байж тухайн газрыг улсын тусгай хамгаалалтад авдаг. Одоо бол бид эхний ээлжид соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэснээ албан ёсоор 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргэсэн байгаа.

О.Номинчимэг: Дараагийн асуудал, ХЗДХЯ-тай холбоотой хэд хэдэн өргөдөл байгаа юм байна. Иргэн Н-ээс Сууц өмчлөгчдийн холбоо /СӨХ/-ны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар хүсэлт, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар ирсэн байна. Иргэн Ц-ээс прокурор, шинжээч, мөрдөгчдийн зүгээс гэмт хэргийг зохион байгуулалттайгаар нуун дарагдуулсан талаар, иргэн Ц-ээс зам тээврийн осол, гэмтэлтэй холбоотой асуудлаар, иргэн Б, иргэн Ц-ээс өөрсдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр цагдаад хандсан боловч цагдаагийн ажилтан арга хэмжээ авахгүй олон дахин нааш цааш явуулж байгаа талаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлт ямархуу шатанд явж байна вэ? Шийдвэрлэсэн бол шийдвэрлэсэн гээд, хувийн нууц мэдээллийг задруулахгүйгээр ерөнхий байдлаар хариулахыг бодоорой. 4 номер.

О.Цолмон: ХЗДХЯ Цолмон, гишүүний асуултад хариулъя. Иргэн Н-тэй холбоотой өргөдөл тус яам дээр 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн УИХ-ын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэгээс шилжүүлэн ирсэн. Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр 10 агуулга бүхий саналыг ирүүлсэн байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан иргэнээс ирүүлсэн саналыг холбогдох судалгааг нь хийгээд ангилаад, тодорхой саналуудыг нь аваад, хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулах асуудал, хамрах хүрээнд хамаарахгүй асуудлуудаар нь холбогдох саналуудыг нь авах боломжгүй болсон талаарх хариуг иргэнд хүргүүлсэн байна.

Иргэн Ц-тэй холбоотой зам тээврийн осолтой холбоотой өргөдлийг дурдлаа. Өнөөдрийн байдлаар иргэн Ц зам тээврийн осолд өртөж хохирсон байж болзошгүй хэрэгт Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсээс нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа юм байна. Тус яаманд иргэн Ц-ээс 2025 оны 9 дүгээр сарын 10-нд, мөн оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд ижил агуулга бүхий гомдлыг ирүүлсэн. Тэдгээр гомдлыг нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хүрээнд харьяаллын дагуу шилжүүлж, ямар арга хэмжээ авсан талаарх мэдээллийг ХЗДХЯ нэгтгэж танилцуулга хэлбэрээр авсан байгаа. Шаардлагатай бол нэмэлт мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээллийг манай Мөрдөн шалгах албанаас зохих хэмжээнд нь өгөхөд бэлэн байна.

Иргэн Ц-ээс ирсэн өргөдлийг дурдлаа. Иргэн Ц-тэй холбоотой нийт 117 удаагийн 331 заалт бүхий өргөдөл, гомдлыг төрийн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байдаг юм байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам, Улсын ерөнхий прокурорын газар гэхчлэн. Эндээс ХЗДХЯ буюу цагдаагийн байгууллагад хандаж нийт 60 хүсэлт гаргасан юм байна. Тэдгээрээс 15-ыг нь бүрэн хангаж, 19-ийг нь хэсэгчлэн хангаж, 26 хүсэлтийг нь хангах боломжгүй талаар холбогдох хариуг нь хүргүүлсэн байна. Хамгийн сүүлийн байдлаар 2026 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр ЦЕГ-ын тэргүүн дэд даргад хандан гомдол гаргасныг нь Чингэлтэй дүүргийн прокурорын газарт хянуулахаар хүргүүлсэн гэсэн ийм мэдээлэлтэй байна.

Иргэн Б болон Ц нартай холбоотой гомдлын талаар дурдсан байна. Цагдаагийн байгууллагад гаргасан гомдлыг нь шалгах ажиллагаа удаашраад гэмтлийн зэрэг тогтоолгох боломжгүй байгаа, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь заналхийлж буй нөхцөл байдал болон цагдаагийн алба хаагчийн эс үйлдэхүйд хянан шалгалт хийлгэж,

эрхээ хамгаалуулах асуудлаар гомдлыг ХЗДХЯ-нд гаргасан. Холбогдох гомдлыг хуульд заасны дагуу ЦЕГ-т шилжүүлсэн. ЦЕГ-аас 26 оны 5 дугаар сарын 7-ны өдөр харьяаллын дагуу Хэнтий аймгийн Цагдаагийн газарт шилжүүлж, холбогдох шалгалтын ажиллагааг явуулсан байна. Хамгийн сүүлийн байдлаар иргэн Ц болон Б нар нь 2026 оны 5 дугаар сарын 9-ний өдөр өргөдөл, гомдлоо буцаан авах хүсэлтийг гаргасан байна. Үүнийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслээд хүсэлтийг нь хангаад, энэ оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 51/2040 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлсэн байна. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Асуулт асуух, тодруулах гишүүн байна уу? Байхгүй байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ төрийн албан байгууллагуудын хоорондын уялдаа холбоогүйтэй холбоотой иргэдийн хохирлын асуудал яригдаж байгаа гэж та бүхэн ойлгоход болно доо. Сая Энхбаяр сайд хэлсэн. Акуа Гарден буюу авлигал гэж нэрлэгдсэн энэ хороололтой холбоотой Дээд шүүхийн шийдвэр өчигдөр гарсан гээд олон нийтийн цахим сүлжээнд тавигдаж байна. Хоёр давхар дээр нь явж байхад би Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүний хувьд холбогдох бүх төрийн байгууллагад үүнтэй холбоотой гарах эрсдэлийг явуулж байсан. Та бүхэн арга хэмжээ аваагүй, өнөөдөр тэнд хэдэн блок байшин баригдсан бэ гэдэг та бүхний нүдэн дээр байгаа. Ялангуяа БХБЯ тухайн үеийнхээр ямар ч арга хэмжээ аваагүй шүү, та нар дараагаар нь хохирсон иргэдийн асуудлыг Хууль зүйн яам, цагдаагийн байгууллага руу чихээд суугаад байж ердөөсөө болохгүй. Энэ маш хариуцлагагүй үйлдэл. Энэ Акуа Гарден буюу авлигал хороолол дээр ирээдүйд маш их хэмжээний хохиролтой холбоотой асуудал яригдах нь бүр хоёр давхар баригдаж явж байх процесс дээр тодорхойлчихсон байсан. Анхных нь зөвшөөрөл өгсөн холбогдох нөхдүүд, энэ барилга баригдаж байх процесс дээр зогсоогоогүй нөхдүүд хариуцлагаа хүлээгээрэй. Маш хүнд асуудлууд энэ дээр үүснэ шүү. Тэр үед нь би анхааруулж байсан шүү.

Тэгээд ингээд төрийн албан тушаалтнуудын хариуцлагагүй байдалтай холбоотойгоор үүсэж байгаа ирээдүйн эрсдэлүүдийг тооцохгүй бол яг өнөөдрийн нөхцөл байдал дээр та бүхэн тэдэн гэмт хэргийг ингэж шийдвэрлэж байна, дандаа араас нь хөөсөн байдалтай л юм ярьж байгаа юм. Яагаад энэ гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх байдлаар та бүхэн ажлаа хийхгүй байгаа вэ? Төрийн байгууллагуудын албан тушаалтнуудын хоорондын уялдаа холбоогүй, сул, хуулиа мэддэггүй, ажлаа хэрэгжүүлж чаддаггүй, үүнтэй холбоотойгоор үүсэж байгаа эрх зүйн хүрээнд үүсэж байгаа үр дагавар нь бий болж байгаа асуудал гэдгийг та бүхэн маш сайн ойлгоорой гэдгийг хэлмээр байна. Түрүүн би гуравхан асуулт асуусан, хариулах албан тушаалтан байхгүй. Ялангуяа Барилга, хот байгуулалтын яам, хот байгуулалтын яам болчихсон, сайд нь үндэсний корпорацаа байгуулаад бүгдийг нь нийлүүлнэ гээд яриад байдаг. Оруулж ирсэн, өргөн барьчихсан байгаа хууль дээр нь тэр нь тусгагдаагүй. Тэгээд энэ чинь маш үл ойлгогдох нөхцөл байдлыг иргэдэд үүсгэж өгч байгаа шүү, тэр Орон сууцжуулалтын хуулиар чинь. Тэгээд ингээд төрийн албан тушаалтнууд нь өөрөө өөрсдөө хариуцлагагүй байдалтай мэдэгдэл, өргөн барьсан хуулийн төсөл дээр нь тэр тухай тусгагдаагүй асуудлыг олон нийтэд яриад явж байгаа юм. Энэ байж болохгүй асуудал. Тэгээд ирээдүйд үүнтэй холбоотой маш олон асуудал үүснэ. Төрийн албан тушаалтнууд хариуцлагатай байх ёстой шүү гэдгийг та бүхэнд би хариуцлагатайгаар эндээс хэлж байгаа юм.

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Дараа дараагийн энэ өргөдөлтэй холбоотой асуудал хүний хувийн мэдээлэлтэй холбоотой, нэр хүндтэй холбоотой асуудал

байгаа учраас нээлттэй биш, хаалттай энэ асуудлуудыг асууж хэлэлцсэн нь гэж харж байгаа учраас ингээд гишүүд маань асуулт асууж, үг хэлж дууслаа.

12.42 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Ажлын хэсэг болон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.УЯНГА